



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН БОЛОН СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ



Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байна

<u>Аудитын тайланг бэлтгэсэн:</u>		АГУУЛГА	
Нийцлийн аудитын газар		Товчилсон үгийн тайлбар	2
		Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, аудит хийх үндэслэл	3-4
		Ерөнхий мэдээлэл	5
Дарга:	Б.Алтанзул	Бүлэг-1. ОНХС-ийн орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалт, түүнд тавих хяналт	
Аудитын менежер:	З.Ариунзаяа	1.1-1.5. Аймаг, нийслэлийн ОНХС-ийн төсөвт уг сангийн орлогын эх үүсвэрүүдийг нарийвчлан тооцож, бүрдүүлэлтийг нь зохих журмын дагуу төлөвлөж тусгаагүй байна	6-10
Ахлах аудитор:	Л.Хонгорзул	1.6. ОНХС-ийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүн, зарцуулалтад тавих хяналт сул байна	10-11
Ахлах шинжээч:	Я.Наранцэцэг	1.7-1.9. Ил тод байдал, иргэдийн оролцоог хангах зарчим бүрэн, жигд хэрэгжихгүй байна	11-19
Аудитор:	Д.Дорждулам	Бүлэг-2. СХС-ийн орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалт, түүнд тавих хяналт	
		2.1-2.3. СХС-ийн хөрөнгийн төлөвлөлтийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгээгүй, уг сангаас зориулалтын бус зээл олгосон байна	20-27
		2.4. ИТХ, ЗД-ын СХС-ийн талаар хүлээсэн үүргийн биелэлт хангалтгүй, хяналт сул байна	27-30
		Дүгнэлт, Зөвлөмж	31-33
		Холбогдох байгууллагын санал	34
		Хавсралтууд	35-36
		Монгол Улсын Ерөнхий аудиторовын тушаал	37
2014 оны 6 дугаар сар			
Уг тайланг УАГ-ын цахим хуудаснаас үзнэ үү:			
www.audit.mn			
<i>Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 263755 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.</i>			
<i>Хаяг: Үндэсний аудитын газар</i>			
<i>Чингэлтэй дүүрэг, Засгийн газрын 4 дүгээр байр, Бага тойруу-3 Улаанбаатар-15160 Монгол Улс</i>			

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

УИХ	Улсын Их Хурал
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
НИТХ	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлэх сан
ДОНХС	Дүүргийн орон нутгийн хөгжлийн сан
НЗДТГ	Нийлэлийн засаг даргын тамгын газар
НХОГ	Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар
НБОНХГ	Нийслэлийн байгаль орчин ногоон хөгжлийн газар
ҮЦХ	Үндэсний цэцэрлэгт хүрээлэн
НӨҮГ	Нийслэлийн өмчит үйлдвэрийн газар
НХААГ	Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар
БЗД	Баянзүрх дүүрэг
СХД	Сонгинохайрхан дүүрэг
СБД	Сүхбаатар дүүрэг
БГД	Баянгол дүүрэг
БНД	Багануур дүүрэг
БХД	Багахангай дүүрэг
НД	Налайх дүүрэг
ХУД	Хан-уул дүүрэг
ЧД	Чингэлтэй дүүрэг
ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
ОНОХАА	Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаа
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, аудит хийх үндэслэл:

1. Аудит хийх үндэслэл: Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2014 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн “Аудитын сэдэв батлах тухай” 03 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудиторос 2014 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу төрийн аудитын хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

2. Аудитын зорилт: ОНХС болон СХС-ийн 2013 оны хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, хэрэгжилтийн байдал хууль, тогтоомжид нийцсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулан дүнг УИХ, холбогдох байгууллагад танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Аудитыг дараах зорилтын хүрээнд хийж гүйцэтгэв. Үүнд:

- ОНХС-ийн орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалт, түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан эсэх;
- СХС-ийн орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалт, түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан эсэх;

3. Аудитын хамрах хүрээ:

Аймаг, нийслэл, сум дүүргийн:

- ОНХС болон СХС-ийн 2013 оны орлого бүрдүүлэлт, төсөв төлөвлөгөө, хуваарилалт, зарцуулалтын байдал
- ИТХ-ын дарга, Засаг дарга, багийн Засаг дарга нараас ОНХС болон СХС-ийн чиглэлээр явуулсан үйл ажиллагаа
- ИТХ-аас сумын хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон байдал
- ИТХ-аас СХС-ийн үйл ажиллагаанд хяналт тавих орон тооны бус зөвлөлийг томилсон байдал
- ОНХС болон СХС-ийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангасан байдал
- ОНХС болон СХС-ийн 2013 оны анхан шатны баримт материал
- ОНХС болон СХС-ийн 2013 оны санхүүгийн үйл ажиллагаа
- ОНХС болон СХС-ийн үйл ажиллагаатай холбоотойгоор иргэдээс авсан санал асуулгын баримт материал

4. Аудитын арга зүй: Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, шаардлагатай нотлох баримт, лавлагаа тайлбар авах, судалгаа, тайлан мэдээг холбогдох байгууллагуудаас гаргуулан нэгтгэж шинжлэх, давтан тооцоолол хийх, санхүүгийн тайлан, хөрөнгийн данс, анхан шатны баримт, ажлын төлөвлөгөө, тайлантай тулган баталгаажуулах зэрэг арга зүй, горимыг хэрэгжүүлэв.

5. Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд: Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль
- Нэгдсэн төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 34 дүгээр тогтоол
- Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоол

- Хөдөлмөрийн сайдын 2013 оны А/38 дугаар тушаал
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт
- Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоол
- Үндэсний статистикийн хорооны 2013 оны статистикийн мэдээ
- Бусад холбогдох хууль, журам

6. Аудитын стандартын талаарх мэдэгдэл: Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, санхүүгийн болон гүйцэтгэлийн шалгалтын журам, гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан аудитын удирдамж, төлөвлөгөө хөтөлбөрийг мөрдлөө.

Ерөнхий мэдээлэл

2013 оноос эхлэн “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан”-ийн орлогыг Төсвийн тухай хуулийн 59, 63 дугаар зүйлд заасны дагуу бүрдүүлж, хуваарилж, орон нутагт хуваарилсан хөрөнгөөр олон нийтийн оролцоотойгоор сонгосон төсөл, хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлж байна.

“**Орон нутгийн хөгжлийн сан** гэж орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон орлогын шилжүүлэг болон аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагч Төсвийн тухай хуульд заасны дагуу бүрдүүлж, хуваарилан зарцуулах хөрөнгийг хэлнэ” гэж МУЗГ-ын 2012 оны 30 дугаар тогтоолд заасан байна.

МУЗГ-ын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан аргачлалыг Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас ОНХС-д олгох шилжүүлгийг тооцоход мөрдөж байна.

Монгол Улсын 2013 оны Төсвийн тухай хуульд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 209.6 тэрбум төгрөгөөр баталсан байна.

- Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 2013 онд гүйцэтгэлээр 190.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг аймаг, нийслэлийн ОНХС-д олгож, орон нутгийн орлогоор 6.4 тэрбум төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж нийт 197.3 тэрбум төгрөгийн орлогын эх үүсвэр төвлөрсөн байна.
- ОНХС-ийн хөрөнгөөр нийт 4840 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээнд 171.0 тэрбум төгрөгийг зарцуулж зөрүү нь орон нутгийн хөгжлийн дансны үлдэгдэл болж үлдсэн байна.

“**Сум хөгжүүлэх сан** гэж сумдад жижиг, дунд үйлдвэр шинээр байгуулах буюу үйл ажиллагааг нь өргөтгөх, сэргээх болон шинээр ажлын байр бий болгох, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор хөнгөлөлттэй зээл олгоход зориулагдсан хөрөнгийг хэлнэ” гэж МУЗГ-ын 2011 оны 134 дүгээр тогтоолд заасан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоолоор “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам, гэрээний загвар”-ыг баталсан байна.

Монгол Улсын 2013 оны Төсвийн тухай хуульд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас СХС-д 24.0 тэрбум төгрөгийн санхүүжилт хийхээр батлагдсаныг Хөдөлмөрийн сайдын 2013 оны А/38 дугаар тушаалаар хуваарилсан байна.

- СХС-ийн 2013 оны нийт эх үүсвэр нь оны эхний үлдэгдэл 12.6 тэрбум, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 24.0 тэрбум, зээлийн эргэн төлөлтөөр 12.1 тэрбум, зээлийн хүүгийн орлого 1.3 тэрбум, хандив тусламж бусад орлогоор 0.3 тэрбум, бүгд 50.0 тэрбум төгрөг байна.
- СХС-аас 7627 төсөлд 42.9 тэрбум төгрөгийн зээл олгосноос 41.2 тэрбум төгрөгийн 7521 төсөл хэрэгжсэн, 1.7 тэрбум төгрөгийн 106 төсөл зээл нь олгогдсон боловч хэрэгжээгүй байна. Үүнд “Сум хөгжүүлэх сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, хяналт тавих журам”-ыг зөрчиж шалгаруулсан төслүүд голчлон хамаарч байна.

**БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ,
БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ ТҮҮНД ТАВИХ ХЯНАЛТ**

ОНХС-ийн орлогын эх үүсвэрийн төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалт түүнд тавих хяналт сул байгаагаас орлого бүрдүүлэх боломжийг ашиглаагүй, хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд сөрөг нөлөөлсөн байна.

1.1. Аймаг, нийслэлийн ОНХС-ийн төсөвт уг сангийн орлогын эх үүсвэрүүдийг нарийвчлан тооцож, бүрдүүлэлтийг нь зохих журмын дагуу төлөвлөж тусгаагүй байна.

Сангийн яаманд хүргүүлсэн “Аймаг, нийслэлийн 2013 оны төсвийн төсөл”-д ОНХС-ийн орлогын талаарх саналаа *Нийслэл, Говь-Алтай, Увс, Завхан аймаг* тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2¹, 14.2.4², 22 дугаар зүйлийн 22.6.3³, 27 дугаар зүйлийн 27.1.7⁴ дахь заалтуудын шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

1.2. *Аймаг, нийслэлийн ОНХС-аас сум, дүүрэгт олгох орлогын шилжүүлгийг Төсвийн тухай хууль, Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам, ОНХС болон ОНХС-аас олгох шилжүүлэг тооцох аргачлалын дагуу төлөвлөөгүй байна. Дунд хугацаанд хэрэгжих иргэдийн оролцоотойгоор гаргасан орон нутгийн хөгжлийн хөтөлбөртэй байх, түүнд тусгасан төсөл хөтөлбөрийг тухайн жилд ОНХС-аас санхүүжүүлэх жагсаалтыг иргэдийн оролцоотойгоор эрэмбэлж гаргах, үүний үндсэн дээр ОНХС-ийн төлөвлөлтийг гүйцэтгэх ажиллагаа эхлэлийн төдий байна.*

Аймаг, нийслэлийн ОНХС-аас сум, дүүргийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн төлөвлөлтийн мэдээлэл, хийсэн судалгаа тооцооноос үзэхэд олон шууд захирагч 2013 оны төсвийн төсөлд ОНХС-ийн орлогын эх үүсвэрийг төлөвлөөгүй, сум, дүүргүүд аймаг, нийслэлийн ОНХС-аас авах орлогын шилжүүлэг, төсөл, арга хэмжээний жагсаалтыг төсвийн төслийн саналын хамт төлөвлөж төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлээгүй нь төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.1⁵, 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.4, 22 дугаар зүйлийн 22.6.3⁶, 27 дугаар зүйлийн 27.2.2⁷, 27.1.7 дахь заалтуудыг зөрчиж байна.

1.3. *ОНХС-ийн орлогын шилжүүлгээс бусад эх үүсвэрийн бүрдүүлэлтийг нарийвчлан төлөвлөөгүй, төсөв болон тодотголын төлөвлөлтийн үндэслэл тооцоонд тавих хяналт хангалтгүй, санаачлага гаргаж ажиллаагүй байна.*

Аймаг, нийслэл, сум, дүүргийн 2013 оны төсвийн төсөлд ОНХС-д төсвийн үндсэн тэнцлийн ашгаас суурь зарлагатай тэнцэх хэсэг, татварын хувь хэмжээг нэмэгдүүлсэн орлого, зарлагын бодит хэмнэлт, дотоод, гадаадын хандив, тусламжаас авах орлогыг тооцсон төслийн саналыг ИТХ-д хүргүүлээгүй байна.

¹ өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах;

² өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах;

³ төсвийн төлөвлөлт, бүртгэл, тайлагналтыг төсвийн ангиллын төрөл тус бүрээр, тэдгээрийн дэлгэрэнгүй ангиллын дагуу бэлтгэх;

⁴ орлого, зарлагыг дотоод гүйлгээнээс бусад нийт гүйлгээний дүнгээр төлөвлөж, бүртгэж, тайлагнах

⁵ төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагддаг төсвийн шууд захирагч нь жилийн төсвийн төслөө жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор харъяалах төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэх

⁶ төсвийн төлөвлөлт, бүртгэл, тайлагналтыг төсвийн ангиллын төрөл тус бүрээр, тэдгээрийн дэлгэрэнгүй ангиллын дагуу бэлтгэх;

⁷ хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгаагдах шинэ болон үргэлжлэн хэрэгжих төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрээр ангилан тусгах.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.10⁸, нийслэлийн ИТХ-ын 2012 оны 79 дүгээр тогтоолоор баталсан “Нийслэл дүүргийн хөгжлийн санг байгуулах, сангийн хөрөнгийг зарцуулах, хуваарилах, тайлагнах журам”-ын 3.5⁹ дахь заалтуудыг зөрчсөн байна.


ОНХС-д орон нутгаас төвлөрүүлсэн эх үүсвэр

/сая төгрөгөөр/

Д/Д	Аймгийн нэр	Төсвийн үндсэн тэнцлийн ашгаас үлдэх хэсэг	Татварын хувь хэмжээг нэмэгдүүлсэн	Хандив	Бусад	Нийт
1	Хэнтий		41.1	996.1	82.9	1,120.1
2	Хөвсгөл		85.0			85.0
3	Ховд			540.0		540.0
4	Дархан-Уул				73.9	73.9
5	Дундговь			10.5		10.5
6	Сүхбаатар		775.2	1,081.7		1,856.9
7	Сэлэнгэ		9.9	87.0	10.9	107.8
8	Дорнод					-
9	Увс					-
10	Баянхонгор				20.4	20.4
11	Нийслэл				494.5	494.5
12	Архангай		35.0		40.0	75.0
13	Булган					-
14	Говь-Алтай					-
15	Баян-Өлгий					-
16	Өмнөговь					-
17	Орхон			24.1		24.1
18	Өвөрхангай					-
19	Төв			1,093.4	316.5	1,409.9
20	Завхан	440.0				440.0
21	Дорноговь					-
22	Говьсүмбэр				144.9	144.9
	Нийт дүн	440.0	946.2	3,832.8	1,184.0	6,403.0

ОНХС-д ОНХНС-ийн санхүүжилтээс гадна орон нутгийн болон хандив тусламжийн орлогоор нийт 6,403.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

ОНХС-д орон нутгаас төвлөрүүлсэн эх үүсвэрийг графикаар харуулбал:



⁸ Энэ хуулийн 25 дугаар зүйлд заасан тусламжийн орлого нь төсвийн орлогын бүрэлдэхүүн хэсэг байна.

⁹ Нийслэл, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд өргөн мэдүүлсэн орон нутгийн хөгжлийн сангийн төсвийн саналыг хэлэлцэж, нийслэл, дүүргийн төсвийн нэг бүрэлдэхүүн хэсэг болгон батлана.

Монгол Улсын 2013 оны төсөвт Улаанбаатар хот, Өмнөговь, Орхон аймаг зарлагаас давсан орлогоос 24.2 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэхээр батлагдаж, бүрэн төвлөрүүлсэн байна.

Төсөв болон төсвийн тодотголын төлөвлөлтийн үндэслэл тооцоо, “ТБОНӨХБАҮХАА-г төлөвлөх, тайлагнах журам”-ын хэрэгжилт, төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд хяналт тавьж, санхүүжилтийг олгох үүрэг бүхий аймаг, нийслэл, сум, дүүргийн СТСХ чиг үүргээ бүрэн гүйцэд хэрэгжүүлээгүй байна. Тухайлбал:

- БНД-ийн СТСХ нь төсвийн тодотголоор хасагдсан төсөл, арга хэмжээ болох “Боловсролын гудамж тохижуулах ажил”-ын зураг төсвийн үнэ 14.7 сая төгрөгийг “Нарлаг хөхий” ХХК-д гүйцэтгэлийн баримтгүйгээр олгосон, “Тусгай хамгаалалттай газрыг тэмдэгжүүлэх ажил”, “Биеийн тамир спорт хорооны засварын ажил”-д урьдчилгаа төлбөрийн баталгаагүйгээр 23.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон.
- СБД-ийн ОНХС-ийн эх үүсвэрээр хийгдсэн ажлуудад НХОГ-аас захиалагчийн хяналт хэрэгжүүлээгүй байхад СБД-ийн СТСХ-ээс НХОГ-т техник хяналтын зардал 20.9 сая төгрөгийг шилжүүлж сангийн хөрөнгийг зүй бусаар зарцуулсан.
- Орхон аймагт орон сууцны дээврийн ажил гүйцэтгэж буй “Женекон групп” ХХК нь гэрээний хугацааг 100 хоногоор хэтрүүлсэн, ажил дуусаагүй байхад гэрээний алданги 47,8 сая төгрөгийг төлүүлж ОНХС-д оруулаагүйг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон, орон нутгийн төсвийн үндсэн тэнцлийн ашиг, татварын хувь хэмжээг нэмэгдүүлсэн нэмэгдэл орлого, зарлагын хэмнэх замаар бий болсон орлогыг ОНХС-ийн эх үүсвэрт хуваарилаагүй зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага өгчээ.

1.4. ОНХС-ийн орлогын шилжүүлгийг хийхдээ батлагдсан хуваарийг мөрдөж ажиллаагүй байна.

Аймаг, нийслэлд ОНХС-д хөрөнгийг хуваарилахдаа Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолын дагуу

- Орон нутгийн хөгжлийн индекс - харгалзах хувийн жинг 25 хувиар,
- Хүн амын тоо - харгалзах хувийн жинг 25 хувиар,
- Хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ - харгалзах хувийн жинг 25 хувиар,
- Орон нутгийн татварын идэвх санаачлага - харгалзах хувийн жинг 25 хувиар хуваарилдаг журамтай.

Тухайлбал: Нийслэлд Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6.¹⁰ 7.7.¹¹, 41 дүгээр зүйлийн 41.1¹² 41.2.4.¹³ зэрэг заалтуудыг зөрчиж ОНХС-аас орлогын шилжүүлгийг нийслэлийн ОНХС-д авч байсан боловч дүүргүүдийн ОНХС-д олгоогүй, 2013 оны 6 дугаар сараас НД, 7 дугаар сараас БЗД, ХУД, СХД, БНД, 8 дугаар сараас, ЧД, БХД, 9 дүгээр сараас СБД, 10 дугаар сараас БГД-т санхүүжилтийг тус тус олгож эхэлсэн бөгөөд 2013 оны 11, 12 дугаар саруудад дүүргүүдэд олгох орлогын нийт санхүүжилтийн 65.0 хувийг олгожээ.

Нийслэлийн СТСХ орлогын шилжүүлгийг нийслэлийн Засаг даргын баталсан сар, улирлын хуваарийн дагуу хийгээгүй байгаа нь ЗГ-ын 2012 оны 30 дугаар

¹⁰ Төсвийн жил эхлэхэд төсвийн захирагчийн тухайн төсвийн жилийн батлагдсан төсвийг зарцуулах эрх нь нээгдэнэ.

¹¹ Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох.

¹² Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ.

¹³ төсвийн сар, улирлын хуваарийг баримталж ажиллах;

тогтоолын 2.5¹⁴ дахь заалтыг зөрчсөн үйл ажиллагаа бөгөөд эрх бүхий байгууллага, албан тушаалтаны тавих хяналт сул байгаатай холбоотой байна.

Сумдын хөгжлийн индексийг 2013 онд Эдийн засгийн хөгжлийн яамнаас тооцож гаргаагүй тул Сангийн яамнаас уг итгэлцүүрийн хувийг бусад үзүүлэлтэд шилжүүлэн 33.3 хувиар тооцох зөвлөмжийг ирүүлсний дагуу сумдын ОНХС-ийн хөрөнгийг хуваарилсан байна.

ОНХНС -аас аймаг, нийслэлийн ОНХС-д 2013 онд олгосон эх үүсвэрийн хуваарилалтыг хүснэгтээр үзүүлбэл:

/сая төгрөгөөр/					
№	Аймгийн нэр	Анх батлагдсан дүн	СЯ-аас шилжүүлсэн дүн	Зөрүү	Санхүүжилтийн хувь
1	Архангай	8,704.1	8,165.6	538.5	93.8
2	Баянхонгор	10,176.2	9,644.0	532.2	94.8
3	Баян-Өлгий	7,646.6	7,106.1	540.5	92.9
4	Булган	7,353.9	6,654.7	699.2	90.5
5	Дархан-Уул	6,915.5	6,589.8	325.7	95.3
6	Дорнод	8,907.9	8,109.2	798.7	91.0
7	Дорноговь	8,130.4	7,646.5	483.9	94.0
8	Дундговь	8,023.4	7,506.4	517.0	93.6
9	Говь-Алтай	9,959.8	9,081.1	878.7	91.2
10	Говьсүмбэр	5,940.1	5,445.0	495.1	91.7
11	Завхан	8,218.4	7,889.4	329.0	96.0
12	Орхон	7,511.1	7,061.8	449.3	94.0
13	Өвөрхангай	9,586.1	8,789.6	796.5	91.7
14	Өмнөговь	9,738.0	8,772.1	965.9	90.1
15	Ховд	8,792.9	8,059.3	733.6	91.7
16	Хөвсгөл	9,358.1	8,619.5	738.6	92.1
17	Хэнтий	8,332.4	8,095.6	236.8	97.2
18	Сэлэнгэ	7,174.2	6,716.3	457.9	93.6
19	Сүхбаатар	8,396.9	8,390.4	6.5	99.9
20	Төв	7,621.7	6,966.6	655.1	91.4
21	Увс	8,095.2	7,554.0	541.2	93.3
22	Улаанбаатар	35,030.6	28,064.9	6,965.7	80.1
	Нийт дүн	209,613.5	190,927.9	18,685.6	92.7

2013 онд ОНХНС-аас аймаг, нийслэлийн ОНХС-д олгох нийт 209,613.8 сая төгрөгийн орлогын шилжүүлгээс гүйцэтгэлээр 190,927.8 сая төгрөгийг олгож, 18,686.0 сая төгрөг буюу 7.3 хувь нь дутуу олгогдсон нь дотоодын НӨАТ, АМНАТ -ын орлого бүрдээгүйтэй холбоотой байна. /хавсралт 1/

2013 онд ОНХНС-аас орлогын шилжүүлэг дутуу хийгдсэн, зураг төсөв нь батлагдаагүй, техник эдийн засгийн үндэслэл хийгдээгүй ажлыг гүйцэтгэхээр төсөв батлуулдаг зэргээс шалтгаалан аймаг, нийслэл, сум, дүүрэгт ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих 371 төсөл, арга хэмжээ огт хэрэгжихгүй болсон, 283 төсөл, арга хэмжээний ажлыг эхлүүлсэн боловч бүрэн дуусгаагүй байна.

1.5. ОНХС-ийн эх үүсвэрийг орлогын нэр төрөл тус бүрээр нь бүрдүүлээгүй, сангийн орлогыг нэмэгдүүлэх боломжийг ашиглаагүй байна.

2013 онд аймаг, нийслэл, сум, дүүргүүдийн ОНХС-ийн эх үүсвэрийг тухайн жилийн төсөв, тодотгосон төсөвт тусгаагүй, төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1¹⁵, 14.2.4¹⁶, 27 дугаар зүйлийн 27.1.1¹⁷, 60 дугаар зүйлийн 60.2.4¹⁸ дэх заалт,

¹⁴ /аймаг, нийслэлийн ОНХС-аас сум, дүүргийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг аймаг, нийслэлийн Засаг даргын баталсан сар, улирлын хуваарийн дагуу сар бүрийн 10-ны өдрийн дотор хуваарилна

¹⁵ Жилийн төсвийн хязгаарт багтаан төсвийн төслийг боловсруулах

¹⁶ Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих болсон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах

Сангийн Сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 4.3.4 дэх заалт, Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан аргачлалын 2.1.4¹⁹, 2.2.3²⁰ дахь заалтуудыг зөрчсөнөөс ОНХС-ийн эх үүсвэрийг бүрдүүлж чадаагүй байна. Тухайлбал:

Орхон аймгийн ОНХС-д орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор аж ахуйн нэгжүүдээс 24.1 сая төгрөгийн хандив тусламжийн орлого төвлөрүүлсэн.

Орон нутгийн төсвийн үндсэн тэнцлийн ашиг 20,061.3 сая төгрөг, татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх, зарлагыг хэмнэх замаар бий болсон 2,212.8 сая, нийт 22,274.1 сая төгрөгийг ОНХС-ийн эх үүсвэрт хуваарилаагүй;

Аймгийн ИТХ-ын тогтоолд үндсэн тэнцлийн ашиг болон ОНХС-д төвлөрүүлэх орлогын эх үүсвэр, мөнгөн дүнг тусгалгүй орхигдуулсан нь гүйцэтгэлээр аймгийн ОНХС-д үндсэн тэнцлийн ашгаас мөнгө төвлөрүүлэхгүй байхад нөлөөлсөн байна.

Төв аймгийн “Орон нутгийн хөгжлийн сан”-д орон нутгийн нийт орлого, суурь орлогын зөрүүгээр 90.0 сая, хандив тусламжаар 1,400.0 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

Сэлэнгэ аймгийн ОНХС-д Бороо гоулд, Болдтөмөр Ерөө гол ХХК-иудаас нийт 87.0 сая төгрөгийн хандивын орлого, Бурхант Хясаат ХХК-д тооцож төлүүлсэн 10.9 сая төгрөгийн алданги, Сант сумын 2012 оны хөрөнгө оруулалтын үлдэгдэл 7.8 сая төгрөг, аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтын данснаас 2,1 сая төгрөгийн хэмнэлтийн орлого, “Хаш Сант” ХХК-иас 0.03 сая төгрөгийн тендерийн орлого зэрэг нийт 107.9 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн;

Сүбаатар аймгийн ОНХС-д Төсвийн тухай хуулийн 56.2-т заасан үндсэн тэнцлийн ашиг 775.2 сая төгрөг, тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор газрын тосны “Вульфпетролеум ХХК” 33.2 сая төгрөг, “Эй пи изкс пи ар өү ХХК” 98.4 сая төгрөг, “Цайртминераль ХХК” 950.0 сая, бусад эх үүсвэрээс 0.1 сая нийт 1,856.8 сая төгрөг төвлөрүүлсэн;

Увс, Баян-Өлгий, Булган, Өвөрхангай, Дорнод, Хөвсгөл, Говь-Алтай, Өмнөговь аймаг ОНХС-д төвлөрүүлэх үндсэн тэнцлийн ашиг гараагүй;

Хэнтий аймгийн ОНХС-д өвөлжилтөнд зориулж албан байгууллага иргэдээс 82.9 сая төгрөгийн хандив тусламж, 41.1 сая төгрөгийн татварын хувь хэмжээг нэмэгдүүлсний орлого нийт 124.0 сая төгрөг төвлөрсөн;

Завхан аймаг төсвийн үндсэн тэнцлийн ашгаас үлдэх хэсэг 440.0 сая, **Дархан-Уул** аймаг бусад орлогоор 73.9 сая, **Ховд** аймаг хандиваар 540.0 сая, **Баянхонгор** аймаг 20.4 сая, **Нийслэл** 494.5 сая, **Говьсүмбэр** аймаг 144.9 сая, **Дундговь** аймгийн Баянжаргалан сум уул уурхайн компаниудаас 10.5 сая төгрөгийг ОНХС-д төвлөрүүлсэн;

Архангай аймаг ИТХ-д орон нутгийнхаа онцлог байдалтай уялдуулан төсвийн тухай хуулиар эрх олгогдсоны дагуу зарим татварын хувь хэмжээг нэмэгдүүлснээс 75.0 сая, **Хөвсгөл** аймаг 85.0 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн;

Дорноговь аймаг ОНХС-д 3.7 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр тооцсон, гүйцэтгэлээр 3,019.1 сая төгрөгийн үндсэн тэнцлийн ашигтай гарсан боловч ОНХС-д мөнгө төвлөрүүлээгүй, өмнөх оны давсан орлого, зарлагын хэмнэлт 1.7 тэрбум төгрөгийг ОНХС-д төвлөрүүлэхгүйгээр урсгал зардалд батлуулж зарцуулсан, **Дундговь** аймгийн Гурвансайхан сум 6.5 сая, Өндөршил сум 7.0 сая, Өлзийт сум 7.9 сая төгрөгийн хандив авч ОНХС-д төвлөрүүлэхгүйгээр зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 60.2.5²¹ дахь заалтыг зөрчсөн байна;

1.6. Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүн, сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт зарим талаар хангалтгүй байна.

¹⁷ Төсвийн зарчмыг мөрдлөг болгох

¹⁸ Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр

¹⁹ Орон нутгийн төсвийн үндсэн тэнцлийн ашгаас суурь зарлагатай тэнцэх хэсгийг тухайн шатны төсөвт үлдээж, үлдэх хэсгийг дээд шатны төсөвт төвлөрүүлэх дүн

²⁰ Төсвийн тухай хуулийн 56.2-т заасан орон нутгийн үндсэн тэнцлийн ашиг

²¹ Тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөх, иргэд, олон нийтийн оролцоог хангахдаа саналын хуудсаар нээлттэй санал асуулга авах, өрх бүлгийн ярилцлага хийх, цахим хэлбэрээр санал авах, иргэдийн саналыг эрэмбэлж тухайн шатны ИТХ-д өргөн мэдүүлэх журмыг зарим аймаг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Тухайлбал;

- Баянхонгор аймгийн Бөмбөгөр, Хүрээмарал, Жаргалант, Баянбулаг сумууд багийн ИНХ-аас ирүүлсэн саналыг эрэмбэлэлгүйгээр шууд сумын ИТХ-д оруулан хэлэлцүүлсэн, Галуут сум иргэдээс санал авсан боловч багийн ИНХ-аар хэлэлцүүлээгүй;

- Сэлэнгэ аймгийн Сайхан сум 305.2 сая, Сант сум 232.0 сая төгрөгийн төсөл арга хэмжээг иргэдийн саналыг авалгүйгээр төлөвлөж батлуулсан.

1.7. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө олон нийтийн оролцоог хангах, ил тод байдлыг хангасан байх зарчмыг бодитой хэрэгжүүлээгүй, иргэдийн саналыг авах талаар журамд заасан хугацааг баримтлаагүй байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлын жагсаалтыг гаргахдаа санал асуулгын хуудсаар нийслэлд дунджаар нийт өрхийн 36.6 хувийг, аймгууд хамгийн бага санал авсан нь 4.5 хувь, хамгийн их санал авсан нь 34.5 хувийг, улсын хэмжээнд дундажаар 13.1 хувийг хамруулсан гэж тайлагнасан боловч зарим орон нутагт санал асуулгын дүнг үнэн бодитой гаргасан талаарх нотолгоо /Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журмын хавсралт “төсөл, арга хэмжээний санал хураах, эрэмбэлэх үйл ажиллагаа”-ны маягтууд, баг, хорооны ИНХ-ын тэмдэглэл, санал асуулгыг эрэмбэлсэн жагсаалт, ИНХ-д оролцсон иргэдийн нэрсийн жагсаалтыг гарын үсгээр баталгаажуулсан тухай баримт гэх мэт/ байхгүй байгаа нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээний санал асуулгад иргэдийн санал үнэн зөв, бодитой тусгагдахгүй байгааг харуулж байна. Тухайлбал:

- Нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний талаарх санал асуулгыг журамд заасны дагуу цахим хэлбэрээр /асуулгыг 7 хоногийн хугацаанд Medee.mn, News.mn, Ulaanbaatar.mn сайтуудад байрлуулсан/ авсан гэж тайлагнасан ч дээрх сайтуудад ямар агуулга бүхий санал асуулгыг байршуулж, иргэдийн хэдэн хувийг оролцуулсан, асуулгын дүнг үнэн бодитой гаргасан талаар нотолгоог аудитын явцад шаардсан боловч гаргаж ирүүлээгүй;

- Завхан, Архангай, Хөвсгөл аймгууд иргэдийн саналыг аваагүй тул хөрөнгө оруулалтын ажлыг эрэмбэлээгүй;

- Орхон аймгийн Баян-Өндөр сумын Засаг дарга ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөх, иргэдээс гарсан саналыг багцлах, орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулах, дүн шинжилгээ хийж эрэмбэлэх үүрэг бүхий ажлын хэсгийг томилж ажиллуулаагүй;

- Санал асуулгад хамруулсан иргэдийн тоо хангалтгүй байх; /Говь-Алтай аймгийн Есөнбулаг сум 0.6 хувь, Бугат, Дарви сумууд 1 хувь, Алтай сум иргэдийн 2 хувиас санал авсан/;

- Увс аймгийн Өмнөговь, Сагил, Тэс, Дорнод аймгийн Матад, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Сүхбаатар сумууд иргэдийн санал асуулга явуулалгүйгээр ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр арга хэмжээг сумын ИТХ-аар шууд батлуулсан;

- Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сум “Хөгжлийн бодлогын ерөнхий төлөвлөгөө” хийлгэх ажилд 50.0 сая, Зүүнбүрэн сум “Иргэний нээлттэй танхим” тохижуулах ажилд 7.5 сая төгрөгийг иргэдийн саналд тусгагдаагүй байхад төлөвлөж батлуулсан;

- Дорноговь аймгийн Улаанбадрах сум I, II, III багийн иргэдийн саналыг авч эрэмбэлээгүй зөвхөн IV багийн иргэдийн хурлыг зохион байгуулж тэндээс гарсан саналыг эрэмбэлж, Замын-Үүд сумын ЗДТГ-ын Захирагчийн ажлын албанд II, III багийн иргэдийн нийтийн хурлын тэмдэглэл, иргэдийн саналыг эрэмбэлсэн, хуралд өргөн мэдүүлсэн баримтууд байхгүй;

- Дорнод аймгийн 6 сум ИТХ-д өргөн мэдүүлэх саналуудын нэгдсэн жагсаалтыг гарган эрэмбэлсэн материалыг ирүүлээгүй, жагсаалтыг ирүүлсэн ч “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 12.2.5.г-д заасан хэрэгжүүлэхээр санал болгож буй төсөл хөтөлбөр, арга хэмжээний тодруулга маягтыг бэлтгэсэн сум байхгүй байгаа нь сумдын ЗДТГ нь саналуудыг боловсруулж эрэмбэлэх ажлыг хангалтгүй хийсэн гэж үзэх үндэслэлтэй байна.

1.8. Иргэдээс ирүүлсэн саналыг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлж, орон нутгийн хөгжилд үр өгөөжтэй, иргэдийн амьдралд нөлөөлөх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг төлөвлөөгүй, тэдгээрийг худалдан авах ажиллагаанд холбогдох хууль, тогтоомжийг мөрдөөгүй байна.

Аймаг, нийслэл, сум, дүүрэгт ОНХС-ийн эх үүсвэрээр 2013 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний талаар иргэдээс ирүүлсэн саналыг нэгтгэж ИНХ-д хэлэлцүүлэх урьдчилсан жагсаалтыг бэлтгэсэн боловч уг жагсаалтад Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам” -ын 12.2.2 а,б, в, г ²²-д заасан “Хөтөлбөр төсөл арга хэмжээг хэрэгжүүлснээс бий болох үр өгөөжийг хэн хүртэх, хэдэн хүн ашиг хүртэх, иргэдийн амьдралд хэрхэн нөлөөлөх, төслийн нийт өртөг” зэрэг үзүүлэлтүүдийг тооцоолж тусгаагүй байна.

Энэ нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний төлөвлөгөөнд төсөвт өртөг, үр ашиг, үр өгөөж нь тодорхойгүй ажлууд батлагдах нөхцлийг бий болгосон байна.

Монгол Улсын хэмжээнд 2013 онд нийт 21 аймаг, нийслэлийн иргэдээс ирүүлсэн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналуудаас тэргүүлэх чиглэл бүхий 5715 төсөл арга хэмжээний саналыг тухайн орон нутгийн хөгжлийн бодлого, нийгэм эдийн засгийн үндсэн чиглэлтэй уялдуулан эрэмбэлж тухайн шатны ИТХ-д өргөн мэдүүлж, хэлэлцүүлэн батлуулсан боловч дараах зөрчлүүд илэрсэн байна. Тухайлбал:

- Аймгийн Засаг дарга сонгогдоогүй, нийгэм, эдийн засгийн үндсэн чиглэл батлагдаагүй зэргээс шалтгаалаад ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажил, төсөл, арга хэмжээний жагсаалтыг Хөвсгөл аймаг ИТХ-аар батлаагүй;
- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажил, төсөл арга хэмжээний талаар санал асуулгын дүнгээр эрэмбэлээгүй, төсөл, арга хэмжээ нэг бүрийг ИНХ-аар хэлэлцүүлээгүй;
- Иргэдийн саналаар дэмжигдээгүй төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн; /Булган аймаг иргэдийн санал өгөөгүй 251.5, Дорноговь 80.0, Говьсүмбэр 748.5, Ховд 0.4, Хөвсгөл 296.0, нийслэл 14.7, Сэлэнгэ 426.7, Увс аймаг 183.0, Хэнтий аймаг 550.9 сая төгрөг/
- ОНХС-аас аймагт хэрэгжих төсөл арга хэмжээний төлөвлөлтийг иргэдээс санал авалгүй аймгийн үндсэн чиглэлийг үндэслэн шууд ИТХ-аар батлуулсан; /Орхон/
- Зарим сум орон нутагт иргэдийн саналыг огт аваагүй; /Говь-Алтай аймгийн Тонхил, Хөхморьт, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Сүхбаатар сумдууд/, санал асуулга авахдаа олон нийтийн саналыг харгалзахгүйгээр өөрсдийн санал болгосон төсөл арга хэмжээний талаар санал авсан; /Баянгол дүүрэг/, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум иргэдээс санал аваагүй ЗДТГ-т граж барихаар 30.0 сая төгрөг төсөвлөсөн, 1 дүгээр багийн иргэдийн хамгийн олон саналтай /203 санал/ Ахуйн үйлчилгээ, халуун усны саналыг дэмжээгүй байна.
- Иргэдийн саналыг баг, хорооны ИНХ-аар хэлэлцүүлээгүй шууд сум, дүүргийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулсан; /Говь-Алтай аймгийн Дарви, Тайшир, Тонхил, Бугат, Хөхморьт, Эрдэнэ, Есөнбулаг сумууд, БГД-ийн 23 хорооны 49683 өрхийн саналыг ИНХ-аар хэлэлцүүлээгүй/
- Санал асуулгад оруулаагүй төсөл арга хэмжээг төсөвт тусгаж батлуулсан; Тухайлбал: /Дорнод 71.0 сая, Дорноговь 695.0 сая, Хөвсгөл 200.0 сая, Говьсүмбэр 155.1 сая төгрөгийн төсөл хөтөлбөр/

²² 12.2.2.а/ хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлснээс бий болох үр өгөөжийг хэн хүртэх; 12.2.2.б/ хэдэн хүн ашиг хүртэх; 12.2.2.в/ сум, дүүргийн иргэдийн амьдралд хэрхэн нөлөөлөх; 12.2.2.г/ төслийн нийт өртөг зэргийг тусгасан байна

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлын худалдан авах ажиллагааны талаар:

ОНХС-ийн хөрөнгөөр 2013 онд хэрэгжүүлэхээр батлагдсан хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороо болон ажлын хэсгийг тухайн орон нутгийн Засаг даргын захирамж, ЗДТГ-ын даргын тушаалаар 5-7 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилон ажиллуулсан байна.

Үнэлгээний хороод нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 дахь заалт болон Сангийн Сайдын 2013 оны 39 дүгээр тушаалаар батлагдсан ОНОХАА-ны журмын дагуу сонгон шалгаруулах үйл ажиллагаа явуулсан боловч сумдад үнэлгээний хороонд ажиллах дадлага туршлагатай, худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн албан тушаалтан ховор, ажлын хэсгийн гишүүд худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажлын туршлагагүйгээс худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж чаддаггүй, тухайн ажил нь ямар өртгөөр хийхэд шаардлага хангах хэмжээнд хүрэхийг тооцохгүйгээр хэт доогуур үнийн саналтай оролцогчтой шууд гэрээ байгуулах, тендерт шалгараагүй иргэн, аж ахуйн нэгжтэй гэрээ хийдэг, шаардлага хангаагүй, үйл ажиллагаа явуулдаггүй, санхүүгийн чадамжгүй аж ахуйн нэгжийг тендерт шалгаруулдаг, ажил гүйцэтгэх гэрээндээ үүрэг хариуцлагыг тодорхой тусгаж өгөөгүй, батлагдсан төсөвт өртөгөөс илүү санхүүжилт олгодог зэрэг зөрчил гаргасан байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулах Үнэлгээний хороо болон ажлын хэсэг нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хуваасан, 14-16 дугаар зүйлийн шалгуурыг хангаагүй гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан, 46.1.6-д заасны дагуу гэрээний биелэлтийг хянаж, дүгнээгүй, зөрчил илэрлээ. Тухайлбал:

- Сэлэнгэ аймгийн Түшиг сум ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлж буй 3 ажилд батлагдсан төсвөөс 0.5-3.1 сая нийт 5.5 сая төгрөгийн санхүүжилт илүү олгосон, Сайхан сум бичил хороолол тохижилтийн 100.0 сая, Сүхбаатар сум хот тохижилтод 170.5 сая, ногоон байгууламжийн ажилд 65.1 сая, гэрэлтүүлгийн ажилд 128.0 сая, хүүхдийн тоглоомын талбай байгуулах ажилд 110.0 сая төгрөгийн ажлыг хэд хувааж харьцуулалтын болон шууд гэрээ байгуулах аргыг сонгож гүйцэтгүүлсэн, Сүхбаатар сумын 5-р багт орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2012 оноос эхлэн баригдаж байгаа ахуй үйлчилгээний төвийн барилга угсралтын ажлыг гүйцээх зорилгоор 2013 онд аймгийн ОНХС-аас 239.2 сая төгрөгийн санхүүжилт хийхээр төсөвлөж улмаар 119.6 сая төгрөгийг шилжүүлсэн нь Төсвийн тухай хууль, ТБОНӨХБАҮХАТХуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн;
- Хөвсгөл аймгийн Мөрөн сум Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр арга хэмжээг төлөвлөхдөө Сангийн сайдын 2012 оы 264 дүгээр тушаалаар батлагдсан “ТБОНӨХБАҮХА ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг зөрчиж зураг төсөв нь батлагдаагүй, техник эдийн засгийн үндэслэл хийгдээгүй ЗДТГ-ын барилга угсралтын ажлын гүйцэтгэгч сонгох тендер зарлаж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан;
- Орхон аймагт Эко хороололын инжинерийн шугам сүлжээний ажлыг гүйцэтгэх 2,150.0 сая төгрөгийн гэрээг байгуулахдаа зураг төсвийн болон техник хяналтын зардлыг тодорхой тусгаагүй боловч аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс техник хяналтын зардалд 35.0 сая төгрөг олгосон;
- Архангай аймгийн Чулуут сум 65.0 сая төгрөгийн дутуу хийгдсэн 3 ажлын гүйцэтгэгч нь ажлаа дуусгаагүй, дутуу орхисон тул дахин гэрээ байгуулахаар захирамж гаргасан;
- Хэнтий аймгийн Батноров суманд 33.0 сая, Хэрлэн суманд 142.6 сая, Норовлин суманд 9.9 сая төгрөгийг тендерт шалгараагүй иргэн, ААН-д шилжүүлсэн;
- Нийслэлд “Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийн сайд нарын 7 дугаар бага хурлын бэлтгэлийг хангуулах сул шороон хөрсийг хайргаар хучих, явган зам нөхөх, зүлэгжүүлэх ажил”-

ын хүрээнд “Хотын гэрлэн чимэглэлийн ажил багц 1 буюу хотын гэрлэн чимэглэлийн ажил”-ыг 3,000.0 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр НЗД-ын 2013 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн А/363 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн 2013 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 05 тоот хурлын тэмдэглэлийг үндэслэн “Сентино Лайтинг” ХХК-ийг шалгаруулж шууд гэрээ байгуулсан байна.


Тендерт шалгарсан “Сентино Лайтинг” ХХК-ийн баримт бичгийг шалгахад:

- улсын бүртгэлийн гэрчилгээний үндсэн үйл ажиллагааны чиглэлд “цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ” хийх эрхгүй /Ажил, үйлчилгээ эрхлэх №926/13 дугаартай тусгай зөвшөөрлийг ЭХЯ-наас 2013 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр 1 жилийн хугацаатай авсан/
- Санхүүгийн чадавхийг нотолсон харилцагч банкны мэдээгдэл ирүүлээгүй, 2011, 2012 оны санхүүгийн тайланд борлуулалтыг “0.0” дүнтэйгээр тайлагнасан нь санхүүгийн чадавхгүй, үйл ажиллагаа явуулдаггүй болохыг, эргэлтийн бус хөрөнгө тайлагнаагүй нь ажлыг хийх техник, тоног төхөөрөмжгүй болохыг нотолж байна;
- Сүүлийн 2 хүртэлх жилийн хугацаанд гүйцэтгэсэн ажлын жагсаалт, тэдгээрээс гүйцэтгэсэн ижил төстэй ажлын өртөг, хугацаа, байршил, бүрэн гүйцэтгэсэн болохыг тодорхойлсон баримт, материал ирүүлээгүй зэрэг нь “Техникийн чадавхи болон туршлага”-ын хувьд шаардлага хангаагүй байна;

Иймд “Хотын гэрлэн чимэглэлийн ажил багц 1 буюу хотын гэрлэн чимэглэлийн ажил”-ыг 3,000.0 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр “Сентино Лайтинг” ХХК-ийг шалгаруулж шууд гэрээ байгуулсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 34 дүгээр зүйлийн 34.2-д заасныг, Сангийн яаманд шууд гэрээ байгуулсан үндэслэлийн талаар мэдээлэл хүргүүлж, зөвшөөрөл аваагүй нь энэ хуулийн 34 дүгээр зүйлийн 34.3²³ гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд иргэдийн төлөөллийг оролцуулах, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд худалдан авах ажиллагаанд мэргэшсэн ажилтнуудыг оруулах асуудалд онцгой анхаарах шаардлагатай байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн нийт төсөл, хөтөлбөр арга хэмжээний ажлыг ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу нээлттэй тендер шалгаруулалтаар 8.7 хувь, харьцуулалтын аргаар 34.7 хувь, шууд гэрээ байгуулах аргаар 56.6 хувиар худалдан авчээ.



²³ 34.3-д “Энэ хуулийн 34.1-д заасны дагуу гэрээ шууд байгуулсан тохиолдолд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ”

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлын гүйцэтгэл, үр дүнгийн талаар:

Монгол Улсын хэмжээнд 2013 онд ОНХС-ийн хөрөнгөөр 5956 хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд 215,638.9 сая төгрөгөөр зарцуулахаар батлагдаж, гүйцэтгэлээр 197,330.9 сая төгрөгийн орлого төвлөрч, 4840 хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд 170,957.6 сая төгрөг зарцуулж, зөрүү нь ОНХС-д үлдэгдлээр үлдсэн байна. /хавсралт 2/

Аудитын явцад ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдсэн төсөл хөтөлбөрийн гүйцэтгэлээр нийт 46,180.8 сая төгрөгийн зөрчил илэрч, нийт санхүүжүүлсэн хөрөнгийн 28.4 хувийг холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг зөрчиж зарцуулсан байна.Тухайлбал:

1. Баянхонгор аймаг 1.9 тэрбум, Хэнтий 2.3 тэрбум, Дорноговь 4.7 тэрбум, Завхан 2.1 тэрбум төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан, Хөвсгөл аймаг 0.2 тэрбум, Дорноговь 0.7 тэрбум төгрөгийн иргэдийн саналаар дэмжигдээгүй төсөл хөтөлбөрийг санхүүжүүлсэн байна;
2. Худалдан авах ажиллагааны журмын зөрчил нийслэлд 3.3 тэрбум, Сэлэнгэд 1.9 тэрбум, Орхон, Баянхонгорт тус бүр 1.0 тэрбум, Төв аймагт 1.2 тэрбум төгрөгийн зарцуулалт дээр гарсан байна.
3. Баянхонгор аймагт 2.0 тэрбум, Хөвсгөл аймагт 0.4 тэрбум, Нийслэлд 3.9 тэрбум, Өвөрхангай 0.6 тэрбум төгрөгийн ажил дутуу буюу чанаргүй хийгдсэн, гэрээний хугацаа хэтэрсэн байна;
4. Өвөрхангай 0.6 тэрбум, Говь-Алтай аймагт 3.5 тэрбум төгрөгийн ажлыг бүртгэл тайланд тусгаагүй, Сүхбаатар аймаг 0.6 тэрбум, Дорноговь 0.1 тэрбум төгрөгийг батлагдсан төсөв болон төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн хувиас илүү тооцож олгосон байна.;
5. Говьсүмбэр 0.7 тэрбум, Хэнтий 0.6 тэрбум, Сэлэнгэ 0.4 тэрбум, Хөвсгөл аймаг иргэдийн саналд тусгаагүй төсөл хөтөлбөрийг 0.3 тэрбум төгрөгөөр санхүүжүүлсэн;
6. Говьсүмбэр аймаг 0.4 тэрбум, Хөвсгөл аймаг 0.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгээгүй ажилд олгосон;
7. Архангай аймаг 0.1 тэрбум, Баян-Өлгий 0.2 тэрбум төгрөгийн ажилд захиалагчийн хяналт тавиагүй;
8. Зарим аймагт */Говь-Алтай аймагт 15 компанитай/* 3-8 ажлыг нэг компанид өгч гэрээ байгуулсан, ажил нь дуусаагүй байхад дахин ажил хийлгэхээр гэрээ байгуулан санхүүжүүлсэн нь тухайн ажлын гүйцэтгэл удаашрах, ажил чанаргүй болох үр дагаварыг бий болгожээ.

ОНХС-ийн зарцуулалтад хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн судалгаа

/сая.төгрөг/

№	Аймгийн нэр	Илэрсэн зөрчил /мян.төг/	Зөрчлийн ангилал								
			Зориулалт бусаар зарцуулсан	Иргэдийн саналаар дэмжигдээгүй ч жагсаалтад орсон	Худалдан авах ажиллагааны журам зөрчсөн	Дутуу буюу чанаргүй хийгдсэн, хугацаа хэтэрсэн	Бүртгэл тайланд тусгаагүй	Төсөвт өртөгөөс илүү санхүүжүүлсэн	Иргэдийн саналд тусгаагүй ажлыг санхүүжүүлсэн	Хэрэгжээгүй, санхүүжилт ээ аваад ажлаа хийгээгүй	Захиалагчийн хяналт тавиагүй
1	Архангай	1,198.9	131.4		389.0	444.2	108.0	16.8			109.5
2	Баянхонгор	4,999.1	1,959.6		953.4	2,010.3				75.8	
3	Баян-Өлгий	311.9	49.4			16.0		7.8		14.2	224.5
4	Булган	413.8	162.3						251.5		
5	Дархан-Уул	13.6						12.0		1.6	
6	Дорнод	129.5	58.5	71.0							

7	Дорноговь	6,020.0	4,729.3	695.0	128.2	285.9		101.6	80.0		
8	Дундговь	224.0	8.0				216.0				
9	Говь-Алтай	4,592.9	140.6			611.3	3,535.6			305.4	
10	Говьсүмбэр	2,459.9	0.8	155.1		869.6	316.5	10.0	748.5	358.0	1.4
11	Завхан	3,120.2	2,129.2		406.5	307.3	1.8			212.5	62.9
12	Орхон	1,684.0	35.0		1,047.0	477.9		34.8			89.3
13	Өвөрхангай	1,131.9	42.4			588.4	501.1				
14	Өмнөговь	305.4	35.8		83.6	186.0					
15	Ховд	1,169.2	534.1			581.2	23.2		0.4		30.3
16	Хөвсгөл	2,302.4	432.9	200.0	419.1	399.0			296.0	555.4	
17	Хэнтий	3,109.5	2,371.4		187.2				550.9		
18	Сэлэнгэ	2,773.8	67.7		1,873.8	315.1		5.5	426.7		85.0
19	Сүхбаатар	881.4				94.0	184.5		602.9		
20	Төв	1,328.1	10.0		1,230.5	87.6					
21	Увс	725.5	410.8		131.7				183.0		
22	Улаанбаатар	7,285.8	21.6		3,307.2	3,907.8		34.5	14.7		
Нийт дүн		46,180.8	13,330.8	1,121.1	10,251.2	11,272.1	4,702.2	825.9	2,551.7	1,522.9	602.9



Дээрх графикаас харахад аудитаар илэрсэн нийт зөрчлийн 29 хувь буюу 13.3 тэрбум төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан, 24 хувь буюу 11.3 тэрбум төгрөгийн ажил дутуу буюу чанаргүй хийгдсэн, гэрээний хугацаа хэтэрсэн, 22 хувь буюу 10.3 тэрбум төгрөгийн ажил худалдан авах ажиллагааны журам зөрчсөн, 10 хувь буюу 4.7 тэрбум төгрөгийн ажлыг бүртгэл тайланд тусгаагүй, 8.7 хувь буюу 3.7 тэрбум төгрөгийн иргэдийн саналд тусгаагүй, иргэдийн саналаар дэмжигдээгүй ажлыг санхүүжүүлсэн, 3.3 хувь буюу 1.5 тэрбум төгрөгийн ажил төсөв батлагдсан боловч хэрэгжээгүй, санхүүжилт аваад ажлаа гүйцэтгээгүй, 3 хувь буюу 1.4 тэрбум төгрөгийн ажлыг төсөвт өртөгөөс илүү санхүүжүүлсэн, захиалагчийн хяналт тавиагүй зэрэг зөрчлүүд эзэлж байна.

ИНХ-аар хэлэлцсэн асуудлаа хуулийн хугацаанд хүргүүлээгүй байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, шаардагдах хөрөнгийг төлөвлөх, зарцуулах үйл ажиллагааг зохицуулсан журам 2012 оны 11 дүгээр сарыг хүртэл гараагүй байснаас Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.1, СС-ын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 12.2.4²⁴ заалт хэрэгжээгүй байна.

²⁴ иргэдийн нийтийн хурал дээр гарсан саналыг тухайн ИНХ-д хэлэлцүүлж тус хурлаас эрэмбэлэгдэн гарсан төслийн жагсаалтыг дүүргийн Засаг даргад 2 дугаар улиралд багтаан хүргүүлнэ.

Энэ нь 2013 оны ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэр санхүүжих төсөл арга хэмжээ тус тусдаа батлагдаж Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.4²⁵, 33 дугаар зүйлийн 33.2.6²⁶ Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан журмын 7.5.7²⁷ 7.6-д заасан заалтууд зөрчигдөх нөхцлийг бүрдүүлсэн байна.

Иргэдийн саналыг ЗДТГ-т эрэмбэлэхдээ холбогдох журмыг бүрэн мөрдөөгүйгээс төлөвлөлтийн бэлтгэл ажил хангагдаагүй, орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдаагүй төсөл арга хэмжээнүүд орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөөнд тусгагдах сөрөг үр дагаварыг бий болгожээ.

- ОНХС-ийн хөрөнгийг зарцуулах саналыг нийслэлийн БЗД, ЧД, СБД, НД-ийн Засаг дарга нар Нийслэлийн Засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр дүүргийн ИТХ-д өргөн мэдүүлсэн;
- ХУД, БГД, БХД, БНД, СХД-ийн Засаг дарга нар 2013 онд ОНХС-ийн хөрөнгийг зарцуулах саналаа НЗД-тай зөвшилцөөгүй нь НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2012 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 79 тоот тогтоолоор баталсан нийслэл, дүүргийн хөгжлийн санг байгуулах, сангийн хөрөнгийг зарцуулах, хуваарилах, тайлагнах журмын 3.3²⁸ заалтыг зөрчсөн;
- Нийслэл, дүүрэгт 2013 онд нийт 714 төсөл, арга хэмжээ эрэмблэгдэж нийслэл, дүүргийн ИТХ-д хүргэгдсэнээс 41.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 499 төсөл, арга хэмжээ батлагджээ. Үүний 70.8 хувь буюу 29.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 251 төсөл, арга хэмжээ зураг төсөвгүй батлагдсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4²⁹, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6.3.3³⁰-д заасныг зөрчсөн;
- Нийслэл, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр 2013 онд нийт 714 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр эрэмбэлж нийслэл, дүүргийн ЗДТГ-аас нийслэл, дүүргийн ИТХ-д хүргэгдэж, 499 төсөл, арга хэмжээ батлагдсаны 9 төсөл арга хэмжээ иргэдээс авсан саналд тусгагдаагүй;
- Орхон аймгийн Баян-Өндөр сумын Зэст баг иргэдийн саналыг эрэмбэлсэн жагсаалт гаргасан боловч тухайн санал хэдэн иргэдийн санал авсан эсэхийг тогтоох боломжгүй, саналын тоо, хуудас байхгүй, Уурхайчин, Эрдэнэ баг иргэдийн саналыг эрэмбэлсэн жагсаалт гаргаагүй, хурлын тэмдэглэл, Зэст, Баянбулаг, Шанд багууд иргэдийн санал асуулгыг багийн ИНХ-аар хэлэлцсэн хурлын тэмдэглэл байхгүй, Цагаанчулуут, Говил, Уурхайчин багын ИНХ-ын тогтоол гаргаагүй;
- Хөвсгөл аймаг ард иргэдийн саналыг хангалттай аваагүй тул эрэмблээгүй;
- Хэнтий аймагт иргэдийн 28.9 хувиас, Орхон аймаг иргэдийн 29.2 хувиас, Баян-Өлгий аймаг 22.5 хувиас, Өмнөговь аймаг 14.8 хувиас, Баянхонгор аймаг 13.4 хувиас, Булган аймаг иргэдийн 19.1 хувиас санал авч эрэмбэлсэн, Говьсүмбэр аймаг 2 төрийн бус байгууллагатай гэрээ байгуулж, иргэдээс санал асуулга авахуулж, судалгаа хийсний үндсэн дээр асуулгыг нэгтгэн эрэмбэлсэн, бусад аймгуудад иргэдийн саналыг эрэмбэлэх ажил хангалтгүй байсан байна.

ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн ашиглалт арчлалт, хамгаалалт, захиалагчийн хяналт хангалтгүй байгаагаас ОНХС-аас санхүүжүүлсэн зарим төсөл хөтөлбөр үр дүнгүй болж байна.

- ОНХС-ийн хөрөнгөөс дүүргийн ИТХ-ын тогтоолоор нэр заан батлагдаагүй төсөл, арга хэмжээнд БНД 14.7 сая, Булган аймаг 251.5 сая, Говьсүмбэр 748.5 сая, Хэнтий 550.9 сая,

²⁵ санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран төсөл нэг бүрийг бүрэн хэмжээгээр тусгах;

²⁶ хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар /нэр, байршил, хүчин чадал, хэрэгжүүлэх хугацаа, төсөвт өртөг, санхүүжүүлэх эх үүсвэр, тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүн/;

²⁷ аймаг, нийслэлийн Засаг дарга хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалтад дараах зүйлсийг тусгана: 7.5.7.а/ төсвийн захирагчийн нэр; 7.5.7.б/ хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний нэр; 7.5.7.в/ байршил; 7.5.7.г/ хүчин чадал; 7.5.7.д/ хэрэгжүүлэх хугацаа; 7.5.7.е/ төсөвт өртөг; 7.5.7.ё/ санхүүжүүлэх эх үүсвэр; 7.5.7.ж/ тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүн.

²⁸ Дүүргийн хөгжлийн сангийн хөрөнгийг зарцуулах саналыг дүүргийн Засаг даргаас Нийслэлийн Засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд өргөн мэдүүлнэ

²⁹ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

³⁰ хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөр арга хэмжээ нь хуульд заасны дагуу техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн, бусад зөвшөөрөлтэй байх

Хөөсгөл 1,345.3 сая, Нийслэл 14.7 сая, Сэлэнгэ 426.7 сая, Увс 183.0 сая төгрөгийг зарцуулж Төсвийн тухай хуулийн 68.1³¹ заалтыг зөрчсөн.

- ХУД, БГД-ийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 868.4 сая төгрөгийн 2 ажил хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцэхгүй, тооцоолсон үр өгөөжийг бүрэн бий болгож чадахгүй байна.
- ХУД-ийн хороодыг камержуулах 198.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлын тендерийг шалгаруулахдаа тендерийн баримт бичигт заагдсан шалгуурыг хангахгүй хүчин чадалтай хяналтын камерууд авсан ба уг суурилуулсан камерууд цахилгааны гэмтлийн улмаас ашиглагдахгүй, ажиллагаагүй байдалтай байлаа.
- БГД-ийн "Нийтийн эзэмшлийн болон орон сууцны гадна талбайг камержуулах" БГД-ХААА/ОН13-05-04 дугаартай ажлыг БГД-ийн ЗД-ын захирамжаар байгуулагдсан Үнэлгээний хороо түлхүүр гардуулах нөхцөлтэйгээр "Лийд линк" ХХК нь 670.0 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр шалгаруулжээ. Ашиглалтын явцад тог баригчийг байрлуулахдаа холбогдох тоног төхөөрөмж, цахилгааны эх үүсвэртэй холбоогүй, тендерт гадна зориулалтын AXIS маркийн, PIXEL counter функц нь 150-200 метрт бичлэг хийх, бичлэгт байгаа хүний царай, тээврийн хэрэгслийн улсын дугаарыг танигдах хэмжээнд томруулан харах чадвартай өндөр үзүүлэлттэй байхаар заагдсан байтал хороонд байрлуулсан хяналтын камер нь 15.6 метр зайд байрлах автомашины дугаарыг танихгүй байдалтай байлаа.
- "Баянгол дүүргийн Сод монгол шатахуун түгээх станцын дэргэдэх талбайн тохижилтын ажил" газар эзэмшлийн маргаанаас цуцлагдсаны улмаас нийслэлийн ОНХС-аас 21.6 сая төгрөгийн үргүй зардал гарсан.
- Баянзүрх дүүргийн 10, 12 дугаар хорооны автобусны буудлын хойд талбайд суурилуулж байгаа 221.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий явган хүний замын хавтан чанарын шаардлага хангаагүй байна.
- Хотын тоосжилтийг бууруулах зорилгоор сул шороон хөрсийг хайрган болон хатуу хучилттай болгосон 530.2 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий хөрөнгө ашиглагч байгууллагын хяналт, хамгаалалт хангалтгүйгээс зарим талбайн хайрга алга болсон, гудамж талбайд суулгасан хавтан ховхорч, хагарч, бутарсан байдалтай байлаа.
- БНД-ийн ОНХС-ийн хөрөнгөөр тусгай хамгаалалттай газрын хилийг тэмдэгжүүлэх 4.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлын гүйцэтгэгчээр "Нүүрэнтэйн орд" ТББ шалгарч, гэрээний дагуу ажлын 50 хувийг гүйцэтгэж 2013 оны 9 дүгээр сарын 3-ны өдөр 2.0 сая төгрөгийн санхүүжилтийг авсан. Үлдэгдэх 50 хувийн ажил нь хийгдээгүй, ОНХС-ийн хөрөнгийг бүрэн шингээж чадаагүй байна.
- Архангай аймгийн доторх замын тэмдэг тэмдэглэгээ, хурд сааруулагч 30.7, хүндэтгэлийн цогцолбор 438.2, хурдан морины гарааны төхөөрөмж, тохижилтын ажил 59.8, аймгийн төвийн таван ЕБС-д утасгүй интернет тавихад 17.5 сая төгрөг тус тус зарцуулагдсан боловч хаана ямар байгууллагад харъяалагдах нь тодорхойгүйгээс өнөөг хүртэл бүртгэл тайланд тусгагдаагүй байна.

1.9. ОНХС-ийн хөрөнгийн хуваарилалт, зарцуулалт оновчтой бус, хуваарилалт хийхдээ холбогдох журам, аргачлалыг хэрэгжүүлээгүй, зарим төсөл хөтөлбөрийн санхүүжилтийг давхардуулан олгосон байна.

ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн нийт ажлын 24.4 хувь нь гэрээний хугацаанд хийгдээгүй, 3.5 хувь нь ашиглагдаагүй, 10.2 хувь нь бүртгэл тайланд тусгаагүй, зарим аймагт хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээг давхардуулснаас зарим бүтээн байгуулалт, тохижилтын ажлууд үр дүнгүй болж байна. Тухайлбал:

³¹ Орон нутгийн төсөвт энэ хуулийн 33.2.1, 33.2.7-д заасныг тусгаж батална.

Архангай аймгийн төвд 412.3 сая төгрөгөөр хийгдсэн гэрэлтүүлэгийн ажил
/Зураг-1/



зураг 1

зураг 2

Архангай аймгийн төвд хийгдсэн 141.6 сая төгрөгийн төсөвт өртөгтөй
явган зам /Зураг 2/-ын ажлууд төсөл арга хэмжээг давхардуулснаас хийгдсэн ажлууд
үр дүнгүй болсон.

Говьсүмбэр аймгийн Мэргэжлийн хяналтын газар ОНХС-ийн санхүүжилтээр
11.5 сая төгрөгөөр хүнсний аюулгүй байдлын багаж тоног төхөөрөмж /зураг 3/ 2013
оны 9 дүгээр сард авсан боловч шинжилгээний дүгнэлт нь хятад хэлээр гардаг тул
ашиглах боломжгүй, бүртгэл тайланд аваагүй байна.



Зураг 3

ОНХС-ийн үйл ажиллагаанд хийсэн Нийцлийн аудитаар нийт 46,180.8 сая
төгрөгийн төлбөр, зөрчил илэрсэн бөгөөд 638.5 сая төгрөгийн 75 төлбөрийн акт
тогтоож, 45,542.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах 207 хугацаатай албан шаардлагыг
холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хүргүүлэв.

БҮЛЭГ 2. СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ, БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ ТҮҮНД ТАВИХ ХЯНАЛТ

2.1. СХС-ийн зээлийн эргэн төлөлтийн эх үүсвэрийн бүрдүүлэлт хангалтгүй, санхүүжүүлсэн хөнгөлөлттэй зээл зориулалтын дагуу ашиглагдахгүй байна.

Суманд үйл ажиллагаа явуулж буй жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийг дэмжих, тэдэнд бага хүүтэй банкны шаардлагаас гадуур зээл олгох, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор Хөдөлмөрийн сайдын 2012 оны А/69, 2013 оны А/38 тоот тушаалаар 2012, 2013 оны “Сум хөгжүүлэх сан”-ийн эх үүсвэрийг тус тус хуваарилаж, төрийн сангийн дансаар дамжуулан сумдад хүргэсэн байна.

Сум хөгжүүлэх сангийн 2013 оны эхний үлдэгдэл 12.6 тэрбум төгрөг, тайлант онд 37.4 тэрбум төгрөгийн орлого орсноос 63.7 хувь буюу 24.0 тэрбум төгрөг нь улсын төсвөөс СХС-д олгосон шилжүүлэг, 35.5 хувь буюу 13.4 тэрбум төгрөг нь зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлт, 0.7 хувь буюу 0.3 тэрбум төгрөг бусад орлого, хандив тусламжаар орж нийт 37.7 тэрбум төгрөгийн санхүүжилт төвлөрсөн байна.

СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ЭХ ҮҮСВЭРИЙН ТООЦОО

/мянган төгрөг/

д/д	Аймгийн нэр	эхний үлдэгдэл	сангийн эх үүсвэр					дүн
			санхүүжилт	эргэн төлөлт	хүү	бусад	хандив	
1	Архангай	1,467,700.0	1,390,000.0	2,105,018.0	127,200.0			3,622,218.0
2	Баянхонгор	1,308,800.0	1,295,000.0	496,000.0	80,500.0	2,000.0		1,873,500.0
3	Баян-Өлгий	1,150,000.0	1,150,000.0	322,100.0				1,472,100.0
4	Булган	1,174,453.6	1,115,000.0	773,970.9	78,797.7			1,967,768.6
5	Говь-Алтай	1,300,400.0	1,135,000.0	583,456.0		72,892.0	3,646.0	1,794,994.0
6	Говьсүмбэр	455,078.0	365,000.0	193,427.6	19,425.5			577,853.1
7	Дархан-Уул		510,000.0	11,950.0	466.3	55.0		522,471.3
8	Дорноговь	1,140,000.0	1,140,000.0	315,500.0	125,800.0			1,581,300.0
9	Дорнод		955,000.0	207,200.0	276,800.0			1,439,000.0
10	Дундговь	201,000.0	1,000,000.0	604,800.0	50,600.0	66,400.0		1,721,800.0
11	Завхан		1,530,000.0	109,742.7				1,639,742.7
12	Орхон		325,000.0					325,000.0
13	Өвөрхангай	1,605,000.0	1,605,000.0	818,300.0				2,423,300.0
14	Өмнөговь		985,000.0	29,343.5	297,936.0			1,312,279.5
15	Ховд	139,200.0	1,225,000.0	701,800.0		3,600.0		1,930,400.0
16	Хөвсгөл		1,620,000.0		73,887.1			1,693,887.1
17	Хэнтий	1,460,115.0	1,340,000.0	591,400.0	32,500.0	60,300.0	82,900.0	2,107,100.0
18	Сүхбаатар	1,238,797.8	940,000.0	687,800.0	56,400.0			1,684,200.0
19	Сэлэнгэ		1,445,000.0		43,900.6			1,488,900.6
20	Төв		1,700,000.0	1,891,200.0				3,591,200.0
21	Увс		1,230,000.0	1,663,800.0				2,893,800.0
нийт дүн		12,640,544.4	24,000,000.0	12,106,808.7	1,264,213.2	205,247.0	86,546.0	37,662,814.9

Дээрх хүснэгтээс үзэхэд Баянхонгор аймагт 2.0 сая, Хэнтий 143.2 сая, Дундговь 66.4 сая, Ховд 3.6 сая, Говь-Алтай 76.4 сая, Дархан-Уул 55.0 сая нийт 346.7 сая төгрөгийн бараа материал борлуулсны орлого, байгаль орчинг нөхөн сэргээх, өвс худалдаж авахад зориулсан хандив, хувийн компаниас багийн засварт өгсөн хандив, номны үнэ гэх мэт бусад орлого оржээ.


Орлогын төрлийг ангилалаар харвал:



Зээлийн эргэн төлөлтийн талаар:


СХС-ийн орлогын эх үүсвэр болох зээлийн үндсэн төлбөр, хүүгийн төвлөрүүлэлт 35.0 хувьтай байгаа нь ажил хариуцсан холбогдох албан тушаалтнууд зээл олголтод хайнга хариуцлагагүй хандсан, эргэн төлүүлэх талаар санаачлагагүй ажилласан, зээлийн ашиглалтын явцад хяналт тавьдаггүйтэй холбоотой байна.

Зээлийн эргэн төлөлтийн байдлыг аймгаар харвал:



2.2. СХС-аас олгосон зээлийн 49.5 хувь нь зориулалт бусаар ашиглагдаж байхад хяналт тавиагүй, хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийг эргэн төлүүлээгүй, хугацаа хэтэрсэн зээлийн хүүг тооцоогүй, зээлийг зориулалт бусаар олгосон нь уг сангийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна.

Улсын хэмжээнд 2013 онд Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөс нийт 7627 төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр 42,936.7 сая төгрөгийн зээлийг жилд 1-3 хувийн хүүтэй, 3 жилийн хугацаатай олгосноос 7521 зээлдэгчийн авсан 41,215.0 сая төгрөгийн зээл нь үр дүнгээ өгч шинээр 10677 байнгын ажлын байр, 1844 түр ажлын байр нэмэгдэж, 6892 ажлын байр хадгалагдсан байна.



Шинээр бий болсон болон хадгалагдсан ажлын байрыг тоогоор, орон нутгаар нь харууллаа.

СХС-аас олгосон зээлийн ангилал:

	Зээлийн ангилал	Зээлдэгчийн тоо	Мөнгөн дүн /сая төг/	Эзлэх хувь
1	Хэрэгжиж байгаа төсөл	7521	41219.0	95.9
2	Төрийн албан хаагч авсан	11	37.8	0.09
3	Үйл ажиллагаа нь түр зогссон, эхлээгүй	29	1,393.2	3.4
4	Хүүгүй олгосон зээл	2	30.0	0.07
5	Харьяа газраа үйл ажиллагаа явуулаагүй	3	16.4	0.04
6	Явуулах үйл ажиллагаа тодорхой бус	61	240.3	0.5
	Нийт дүн	7627	42,936.7	100.0

Шалгаруулсан нийт төслөөс 106 төслийн 1,717.7 сая төгрөгийн зээлийг Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тушаалаар батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, хяналт тавих журам”-ыг зөрчиж шалгаруулсан байна. Тухайлбал:

- Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын “Оёдол үйлдвэрлэл” төсөл хэрэгжүүлэгч О.Наранбаатар, “Гутал зан засвар” төсөл хэрэгжүүлэгч М.Баямбаа, “Сур суран эдлэл” төсөл хэрэгжүүлэгч Р.Эрдэнэхүү нар үйл ажиллагаа эрхлээгүй, тус суманд оршин суудаагүй өөр аймаг суманд амьдарч байна.
- Ховд аймгийн Булган сумын төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн шийдвэргүйгээр Жаргалант сумын иргэн Билэгдэмбэрэлд 25,0 сая, Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн иргэн Баастад 2.0 сая бүгд 27.0 сая төгрөгийг олгосон.
- Төв аймгийн Зуунмод сумын иргэн Д.Дагважанцан 2013 оны 5 дугаар сард цэвэр усны үйлдвэрлэлийн чиглэлээр 50.0 сая төгрөгийн зээл авсан боловч орон нутагтаа үйл ажиллагаа явуулаагүй, Ц.Батбаяр 2013 оны 5 дугаар сард модон эдлэлийн чиглэлээр 16.0 сая төгрөгийн зээл авсан үйл ажиллагаа эхлээгүй, иргэн М.Энхтуяа 2013 оны 5 дугаар сард сүү үйлдвэрлэлийн чиглэлээр 10.0 сая төгрөгийн зээл авсан үйл ажиллагаа эхлээгүй, Оорцогшанд ХХК 2013 оны 5 дугаар сард ногооны зоорь барих 20.0 сая төгрөгийн зээл авсан үйл ажиллагаа явуулаагүй, иргэн Б.Нямцэрэн 2013 оны 5 дугаар сард оёдлын чиглэлээр 15.0 сая төгрөгийн зээл авсан үйл ажиллагаа явуулаагүй, Лхамхайрхан ХХК 2013 оны 5 дугаар сард блок үйлдвэрлэлийн чиглэлээр 12.0 сая төгрөгийн зээл авсан үйл ажиллагаа явуулаагүй, иргэн Д.Баянбаатар 2013 оны 12 сард 10.0 сая төгрөгийн зээл авсан үйл ажиллагаа явуулаагүй;

- Өмнөговь аймгийн Булган сумын Д.Буяндалайгийн “Тахианы аж ахуй”, С.Сугирын “Оёдол”, А.Ганзоригийн “Кофе шоп”, Л.Идэрсайханы “Тоосгоны үйлвэрлэл”, Баяндалай сумын Ц.Сумъяагийн “Зургийн студи”, Б.Оюунбатын “Хэрчсэн гурил банш цех”, Т.Гүнцацралын “Гар урлал”, Ханхонгор сумын А.Ганхүүгийн “Оёдол” зэрэг нийт 230.1 сая төгрөгийн төслүүд одоог болтол хэрэгжээгүй;
- Журмын 1.6.1, 1.6.2, 3.1.2, 3.1.3 дахь заалтуудыг мөрдөж сумдад зээлийн хүүг жилийн 3 хүртэл хувь, нэг төсөлд олгох зээлийн дээд хэмжээг 50.0-70.0 сая төгрөг, доод хэмжээг 2.0-4.0 сая төгрөг, зээлийн хугацааг 36 сар хүртэл байхаар тогтоон журам гаргасан боловч зарим сумууд журмаа мөрдөж ажиллаагүй /Баян-Өлгий аймгийн Сагсай, Баяннуур, Бугат зэрэг сумуудад 300.0-1,000.0 мянган төгрөгийн хооронд зээл олгож байгаа нь төслийг үр ашигтай, ажлын байр нэмэгдүүлэх, зориулалтын дагуу зарцуулах боломжийг бүрдүүлэхгүй зөвхөн хэрэгцээний зээл маягаар ашиглаж байгаа гэж үзэхээр байна/;

Олгосон зээлийн дийлэнх хувь буюу 30.5 хувийг хөдөө аж ахуйн чиглэлийн 2289 төсөл арга хэмжээнд, 24.5 хувийг хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлийн 1844 төсөлд, 14.2 хувийг хүнсний үйлдвэрлэлийн чиглэлийн 1070 төсөлд, 7 хувийг барилгын материалын чиглэлийн 523 төсөлд, 23.8 хувийг бусад чиглэлийн 1795 төсөлд олгосон байна.

Хэрэгжиж байгаа төслийг үйл ажиллагааны чиглэлээр нь харуулбал:



Аймаг, нийслэл дүүрэг	Дэмжигдсэн төслийн тоо / үйл ажиллагааны чиглэл/							
	Хүнсний үйлдвэр	Хөнгөн үйлдвэр	Газар тариалан	Мал аж ахуй	Барилга	Худалдаа үйлчилгээ	Бусад	НИЙТ
Архангай	63	43	27	48	27	15	18	241
Баян-Өлгий	68	139	64	34	18	80	83	486
Баянхонгор	62	178	59	31	14	2	13	359
Булган	20	19	54	35	22	46	14	210
Говь-Алтай	118	48	35	51	18	80	0	350
Говьсүмбэр	6	9	6	11	5	11	12	60
Дархан-Уул	27	37	29	52	11	54	0	210
Дорноговь	40	45	15	27	15	47	16	205
Дорнод	46	45	31	32	17	10	62	243
Дундговь	65	115	65	120	85	95	114	659
Завхан	59	95	56	38	8	55	20	331
Орхон	11	28	17	21	13	8	13	111
Өвөрхангай	110	129	85	97	39	35	128	623
Өмнөговь	37	51	24	36	25	44	54	271
Сүхбаатар	19	50	34	23	24	25	43	218

Сэлэнгэ	80	71	75	147	47	43	134	597
Төв	50	175	125	284	54	94	23	805
Ховд	48	141	48	45	21	0	85	388
Хөвсгөл	57	175	32	93	26	31	9	423
Хэнтий	36	57	56	15	14	53	64	295
Увс	48	194	83	29	20	49	13	436
НИЙТ ДҮН	1070	1844	1020	1269	523	877	918	7521

СХС-ийн дансыг зориулалт бусаар ашигласан зөрчлийн талаар дурьдвал:

Говь-Алтай аймгийн Алтай сум: ИТХ-ийн даргын өрөөний тохижилтын ажилд 1.0 сая төгрөг, сайн малчны шагналд 0.3 сая төгрөг, 3 хүнд буцалтгүй тэтгэмж 1.6 сая төгрөг, Мандиймаад олгосон түр зээл 0.35 сая төгрөг, ааруулын үнэнд 1.0 сая төгрөг, Нутгийн зөвлөлд 1.6 сая төгрөг, бусад жижиг зориулалт бус зардалд 0.54 сая төгрөг нийт 6.3 сая төгрөг, Бигэр сум бусад зардалд 0.84 сая төгрөг, Жаргалан сум гамшигийн зардалд 1.0 сая төгрөг, Тайшир сум тэжээлийн үнэнд 0.6 сая төгрөг, Цээл сум бусад зардалд 6.7 сая төгрөг, Шарга сум шатахууны зардалд 0.3 сая төгрөг, Эрдэнэ сум багийн төвийн тохижилт, нохой устгал, шатахуун, модны суулгацын зардалд 22.0 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан;

Мөн Алтай сум СХС-ийн дансаар орон нутгийн ерөнхий орлого, ангилагдаагүй зардал, ЗДТГ-ын тэтгэмж, хандив, мотоцикль, морин хуур, станц борлуулсны үнийг оруулж, нөхөн сэргээлтийн хяналтын зардалд 5.0 сая төгрөг, тэжээлийн үнэнд 2.1 сая төгрөг, ХЦА-д 2.0 сая төгрөгийн тэтгэмж, Нийтлэг-Үйлчилгээ” ОНТҮГ нь LED дэлгэц авахад 5.0 сая төгрөг зарцуулах зэргээр нийт 20.6 сая төгрөгийг СХС-ийн дансаар дамжуулан зарцуулсан;

Сэлэнгэ аймгийн Хушаат сум 25 жилийн түүхэн баримтат кино бүтээхэд 3.9 сая төгрөг, Засаг даргын захиралжаар аялал зугаалгад 1.7 сая төгрөг, эмчилгээний төлбөрт 1.0 сая төгрөг нийт 6.6 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан, Сүхбаатар сум иргэн П.Идэрпүрэвт 4.6 сая төгрөг, Мандал сум иргэн С.Батбаатарт 5.0 сая төгрөгийг зээлийн гэрээнээс илүү олгосон, Түшиг сум зээл олгосон иргэдээс тус бүр 10.0 мянган төгрөг буюу нийт 300.0 мянган төгрөгийн ХХОАТ суутган авсан;

Дорнод аймгийн Дашбалбар сум 12 иргэнийг орон сууцтай болгоход дэмжлэг үзүүлэх зорилгоор 74.9 сая төгрөгийг 2.4 хувийн хүүтэй, 5-6 жилийн хугацаатай олгосон;

Баянхонгор аймгийн Гурванбулаг, Жаргалант сумын ЗДТГ-ын үйл ажиллагаанд 2.8 сая төгрөг зарцуулсан;

Сүхбаатар аймгийн Мөнххаан сум СХС-аас 3.7 сая төгрөгийг ЗДТГ-ын цалинд зарцуулсан;

Хөвсгөл аймгийн Арбулаг сум СХС-аас ЭМГ-ын ойд зориулж 500.0 мянган төгрөгийн хандив олгосон, Шинэ-Идэр сумын СХС-аас иргэн Гомбосүрэнгийн дансанд 1.0 сая төгрөгийг зориулалт бусаар шилжүүлсэн;

Архангай аймгийн Өгийнуур сумын ЗДТГ-т СХС-аас 5.0 сая төгрөгийн өөс тэжээлийн нөөц бэлтгэсэн, 4.0 сая төгрөгийг зээлийн төсөл шалгаруулалгүй шууд олгосон, ЗДТГ-т 1.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, Хотонт сумын ЗДТГ СХС-аас 1.1 сая төгрөгийг нутгийн зөвлөлийн уулзалтын арга хэмжээнд, Цахир сум сумын төвийн гудамжны гэрэлтүүлэгт 20.0 сая, нутгийн зөвлөлийн уулзалтад 2.5 сая төгрөг зарцуулсан, Жаргалант сум иргэн Ч.Батсайханд 25.0 сая төгрөгийн зээлийг дэд станц барих чиглэлээр олгосон бөгөөд энэ ажил нь 2013 оны ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажилтай давхардсан;

Өмнөговь аймгийн СХС-ийн дансанд Малжуулах төслийн эргэн төлөлтийн 2,720.0 мянга, Байгаль хамгаалах сангийн барьцааны 120.0 мянга, сумын Төрийн банкинд байршиж байсан СХС-ийн үлдэгдэл төвлөрүүлсэн 4,700.0 мянган төгрөг нийт 7,540.0 мянган төгрөгийг оруулан зарцуулсан;

Хэнтий аймгийн Дархан сум 72.7 сая төгрөг, Мөрөн сум 7.8 сая төгрөг, Цэнхэрмандал сум 1.4 сая төгрөг, Хэрлэн сум 8.8 сая төгрөгийн хандив тусламжийг сум байгуулагдсаны ой, өвөлжилтийн бэлтгэл, байгаль орчин хамгаалах зэрэг зориулалтаар цуглуулж СХС-ийн дансаар оруулж зарцуулсан;

Төслийг үр дүнгүй, зориулалт бусаар зарцуулах, төслөө огт хэрэгжүүлэхгүй байх, дутуу гүйцэтгээд орхих зэрэг зөрчил дутагдлууд их байгаа ч зарим төсөл

хэрэгжүүлэгч нар авсан зээлээ зориулалтын дагуу үр дүнтэй хэрэгжүүлж, орон нутгийн хөгжилд зохих хувь нэмрээ оруулж байгаа олон иргэн, аж ахуйн нэгж байна. Тухайлбал:

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 2-р багийн иргэн Р.Машбат нь өнгөлгөөний тоосго хийх зориулалтаар 20.0 сая төгрөгийн зээл авч өнгөлгөөний хавтан, тоосго үйлдвэрлэх тоног төхөөрөмж, түүхий эд бэлтгэсэн, ажлын байр шинээр бий болгожээ. /Зураг-4/



Зураг 4

Дундговь Сайхан-овоо сумын иргэн Б.Нармандах “Газар шим” төслөөр сум хөгжлийн сангаас 5,0 сая төгрөгийн зээл авч төмс хүнсний ногоо тарьж худалдан борлуулахын зэрэгцээ тахиа, гахайны аж ахуй эрхлэн төслөө амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна. /Зураг 5/



Зураг 5

Сайнцагаан сумын иргэн Ц.Энхсайхан “Лабораторийн тоног төхөөрөмж” төслөөр сум хөгжлийн сангаас 10,0 сая төгрөгийн зээл авч шинжилгээний орчин үеийн тоног төхөөрөмж худалдан авч “Онч” биохими дархлаа судлалын хувийн Лабораторийг байгуулан бүх төрлийн шинжилгээ авч ирээдэд түргэн шуурхай чанартай үйлчилж байна. /Зураг6/



Зураг 6

Сайнцагаан сумын иргэн Э.Энхсоёл нь сум хөгжүүлэх сангаас “Хүүхдийн цэцэрлэг тохижуулах” төслөөр 5.0 сая төгрөгийн зээл авч хувийн цэцэрлэгийг тогтмол ажиллуулж ирээдийн хүүхдийг тав тухтай тохилог орчинд хүмүүжүүлж байна. /Зураг 7/



Зураг 7

2.3. СХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл сонгон шалгаруулалт журмын дагуу явагдаагүй, чанаргүй, эдийн засгийн тооцоо, судалгаа муутай төслийг шалгаруулсан байна.

СХС-ийн хөрөнгөөр төсөл арга хэмжээний төсөл сонгон шалгаруулалтыг Засгийн газрын 134 дүгээр тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-д зээл олгох төслийн 5 шалгуур үзүүлэлт, зээлдэгчид тавигдах 3 шалгуур үзүүлэлт болон төсөл сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг ИТХ-ын тогтоолоор байгуулах талаар заажээ.


Сумдад дээрх тогтоолоор баталсан журмын дагуу СХС-ийн төсөл сонгон шалгаруулах зөвлөл, хяналт тавих ажлын хэсгийг тус тус томилж, иргэдээс ирүүлсэн төслийг тус орон тооны бус Зөвлөл хэлэлцэн баталж байна.

Сумдууд сангийн хөрөнгөөр зээл олгохтой холбогдуулан сумын хөгжлийн тэргүүлэх чиглэлийг орон нутагтаа жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох зорилгод нийцүүлэн ямар салбарт эрэлт хэрэгцээ их байгааг нарийн судлаагүй, тэргүүлэх чиглэлээ оновчтой тодорхойлж чадаагүй, зарим суманд батлаагүй, сумын хэмжээнд төсөл сонгон шалгаруулахад иргэдийн оролцоог хангаагүйгээс төдийлөн сайн төслийг сонгон шалгаруулж чаддаггүй байна.

Төсөл сонгон шалгаруулах хурлын тэмдэглэлийг зарим сумдад тодорхой бичдэггүй, нэгтгэн дүгнээгүйгээс хэнд, хэдэн төгрөгийн зээл олгохоор баталсан нь тодорхойгүй байна.

Төсөл сонгон шалгаруулах орон тооны бус Зөвлөл нь зээлдэгч нарын ирүүлсэн төслийн эдийн засгийн тооцоо, судалгаа, учирч болзошгүй эрсдлийг урьдчилан тооцоолох чадвар муу, иргэдийн төлбөрийн чадварыг нарийвчилан тодорхойлоогүйгээс банкны зээлтэй иргэдэд зээл олгосон, мөн ажлын байрыг нэмэгдүүлэх ёстой байтал байнгын ажлын байртай иргэнд зээл олгосон, зээл хэлэлцэхээс өмнө зээлийн судалгааг СХС хариуцсан мэргэжилтэн объект дээр нь очиж судалгаа хийдэггүйгээс зээлийн хөрөнгийг зориулалт бусаар ашиглах явдал их байна.

Зөвхөн Говь-Алтай аймгийн иргэдээс авсан санал асуулгыг танилцуулахад: Судалгаанд нийт бүх сумдын 283 иргэн оролцлоо. Иргэдийн 43 хувь нь ил тод байдаг, 13.0 хувь нь ил тод ба шударга бус байдаг, 12.0 хувь нь хамаатан саднаа шалгаруулдаг, 33.5 хувь нь энэ талаар мэдэхгүй гэж хариулжээ. Эндээс харахад оролцогчдын зөвхөн 43 хувь нь ил тод байдаг гэж хариулсан нь төсөл сонгон



шалгаруулах зөвлөлийн үйл ажиллагаа ил тод бус, шударгаар явагдахгүй байгааг харуулж байна.

СХС-ийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулдаг, төслийг сонгон шалгаруулахдаа сум орон нутгийнхаа онцлогийг харгалзан үзэж, нэн тэргүүнд

шаардлагатай тэргүүлэх чиглэлийг санхүүжүүлэхээр сонгоогүй, зарим суманд аль болох олон хүнийг хамруулах зорилгоор нэг чиглэлийн төсөлд 300.0-1000.0 мянган төгрөгийн жижиг зээл олгосон, иргэдээс ирүүлсэн төслийг нэг удаагийн хурлаараа хэт олноор хэлэлцсэнээс төсөл сонгон шалгаруулалт чанаргүй болдог, тухайн орон нутагт оршин суудаггүй иргэнд зээл өгдөг, зээл аваад төслөө хэрэгжүүлдэггүй зэргээс СХС-ийн зорилго алдагдаж, хэрэгжүүлсэн төсөл үр дүнгүй болсон байна. Тухайлбал:

Баян-Өлгий аймгийн сумдууд 300.0 – 1,000.0 мянга, Завхан аймгийн сумдууд ихэвчлэн 1,000.0-2,000.0 мянган төгрөгийн зээл олгодог, Увс аймгийн Малчин суманд 38 төсөлд 103.0 сая төгрөгийн зээл олгосон;

Дундговь аймгийн Гурвансайхан суманд хэрэгжиж байгаа “Оёдол” төсөл 2.0 сая төгрөгийн, Сайхан-Овоо сумын “Гутал захиалгаар үйлдвэрлэх” төсөл 5.0 сая төгрөгийн зээл авсан боловч тоног төхөөрөмж авах санхүүжилт хүрэлцээгүй, эргэлтийн хөрөнгө дутмаг гэсэн шалтгаанаар хувь хүнээс нэмж зээл авч давхар зээл төлж байгаагаас авсан зээлээ хугацаанд нь төлж чадахгүй болсон;

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сум 103 төслийг нэг удаагийн хурлаар хэлэлцсэн;

Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийг зоогийн газар, эрчимжсэн мал аж ахуй, хүүхдийн цэцэрлэг, газар тариалан, оёдлын үйлдвэр, хүүхэд өнжүүлэх төв, дугуй засвар, үсчин гоо сайхан, модон эдлэл, бууз баншны цех, талх, нарийн боовны цех, гар урлалын чиглэлийн үйлдвэрлэлд түлхүү олгожээ.

2.4. СХС-ийн тайлан мэдээг тайлант хугацаанд хүргүүлсэн ба ИТХ, ЗД-ын үүргийн биелэлт хангалтгүй, орон тооны бус зөвлөлийн хяналт сул, зөрчил гаргасан этгээдэд хариуцлага хүлээлгэх ажиллагаа журмын дагуу явагдаагүй байна.

“Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих” журмын 3.3-д зааснаар “Төсөл сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор долоон гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллуулна. Төсөл сонгон шалгаруулах зөвлөлийг сумын Засаг дарга ахлах бөгөөд зөвлөлийн гурван гишүүн нь тухайн сумын иргэний төлөөлөл байна” хэмээн тусгасан байдаг.

Сум бүр сангийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалт, зээлийн эргэн төлөлттэй холбоотой мэдээллийг Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тушаалаар батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 5.4-т заасан хугацаанд аймгийн Хөдөлмөрийн хэлтэст хүргүүлэн ажиллажээ.

Хөдөлмөрийн хэлтэст сумдаас СХС-ийн зарцуулалтын талаарх мэдээ тайланг файлаар ирүүлж байгаа нь шаардлага хангахгүй, тухайн мэдээ үнэн зөв эсэхийг нотлох анхан шатны баримтгүй, СХС-ийн зарцуулалтын тайлан цаг хугацаа хоцрох, хэрэгжилт хангалтгүй, үр дүнг тооцох боломж хязгаарлагдмал байна.

Цаашид Хөдөлмөрийн хэлтэс нь СХС-ийн хөрөнгийн зарцуулалтын тайланг сумдаас албан ёсны, нотлох баримтаар баталгаажуулан хугацаанд нь гаргуулан авч Хөдөлмөрийн үйлчилгээний төвд хүргүүлж ажиллах шаардлагатай байна.

СХС-ийн бие даасан тайлан гаргадаггүйгээс төрийн сангийн зүгээс тавих хяналт сул, аудитад хамрагддаггүй тул дансаар мөнгө дамжуулдаг, өр авлагаа дутуу тусгадаг зөрчлүүд нийтлэг байна.

СХС-ийн үйл ажиллагааны тайланг сан хариуцсан мэргэжилтэн журамд заасны дагуу жилд хоёроос доошгүй удаа шалгалт хийж дүнг ИТХ-аар хэлэлцүүлж, сумын нийт иргэдэд мэдээлж байх ёстой боловч Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын 5.3-т заасныг зөрчиж сангийн үйл ажиллагаа, зээлийн хэрэгжилтийг ихэнх сум ИТХ-аар хэлэлцүүлээгүй, иргэдэд мэдээлдэггүй байна.

Орон тооны бус хяналтын Зөвлөл журмын дагуу ажиллаагүй, хяналт шалгалт хийсэн тайлан байхгүй, хяналт тавиагүйгээс журам зөрчигдөх, зээлийн үр дүн буурах, хугацаандаа төлөгдөөгүй хугацаа хэтэрсэн зээл өсөх, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бизнест эрсдэл үүсэх нөхцөл бүрдсэн байна.

Зарим сумдын ажлын хэсгийг байгуулсан шийдвэрт дараах дутагдал гарсан байна. Тухайлбал:

Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын ажлын хэсгийг байгуулсан тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавих үүргийг тухайн ажлын хэсэгт даалгасан, Жаргалант сумын сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд хяналт тавих ажлын хэсгийн даргаар ЖДҮ хариуцсан мэргэжилтэн томилсон байгаа нь өөрөө өөртөө хяналт тавихаар болсон байна.

2013 онд Дундговь, Говьсүмбэр, Хөвсгөл, Увс, Сүхбаатар, Баян-Өлгий аймгууд зарим сумдын сум хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн бүрэлдэхүүн, төсөл сонгон шалгаруулсан байдал, зээлдэгч иргэдийн ажлын явц, зээлийн хэрэгжилтэд аймгийн хөдөлмөрийн хэлтэс болон СХС-ийн орон тооны бус зөвлөлөөс хяналт шалгалт хийж, сумдад зөвлөмж өгч ажилласан боловч үр дүн гараагүй, зээлийн хугацаа хэтрэлт арилаагүй байна.

Цаашид орон нутагтаа үйлдвэрлэл бий болгох, үр өгөөжтэй томоохон зээлийг санхүүжүүлэх, чанаргүй зээл олгосон, хяналт тавьж ажиллаагүй албан тушаалтанд хариуцлага тооцох тогтолцоог хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Сум хөгжүүлэх сангийн зээлийг олгосноор орон нутагт санхүүгийн эрх мэдэл олгогдсон, арилжааны банкаар дамжуулахгүй олгож байгаа нь иргэдэд чирэгдэлгүй болсон, сумдын удирдлага жижиг дунд үйлвэрлэлийг дэмжих идэвх сайжирч, иргэдийн санал санаачлага нэмэгдсэн, иргэд бие биедээ хяналт тавих нөхцөл бүрдсэн зэрэг давуу талууд бий болсон хэдий ч зөрчил дутагдал байсаар байна. Тухайлбал:

- *Сумдууд тэргүүлэх чиглэлээ тодорхойлоогүй, ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулаагүй; /Өвөрхангай аймгийн Есөнзүйл, Өлзийт, Сант, Уянга, Тарагт, Зүүнбаян-Улаан, Бүрд, Хужирт, Бат-Өлзий, Хайрхандулаан сумдын ИТХ сумын тэргүүлэх чиглэлийг тодорхойлоогүй/*
- *Иргэдээс ирүүлсэн төслийг сайтар судлаагүйгээс эдийн засгийн тооцоо судалгаагүй, чанаргүй зээлийг сонгон шалгаруулдаг; /Өмнөговь аймгийн Булган, Номгон, Мандал-Овоо, Ханхонгор, Цогт-Овоо, Даланзадгад/*
- *Зээлийн хөрөнгөөр төслөө хэрэгжүүлээгүй; /Төв аймагт иргэн Д.Дагважанцан Цэвэр усны үйлдвэрлэлийн чиглэлээр 50.0 сая төгрөгийн зээл авсан боловч орон нутагтаа үйл ажиллагаа явуулаагүй, иргэн Ц.Батбаяр модон эдлэлийн чиглэлээр 16.0 сая, иргэн М.Энхтуяа сүү үйлдвэрлэлийн чиглэлээр 10.0 сая, Оорцогшанд ХХК ногооны зоорь барих 20.0 сая, иргэн Б.Нямцэрэн оёдлын чиглэлээр 15.0 сая, Лхамхайрхан ХХК блок үйлдвэрлэлийн чиглэлээр 12.0 сая, иргэн Д.Баянбаатар 10.0 сая, Увс аймгийн Ховд сумын иргэн Р.Юнгэрэн гэрийн дээс ноосон эдлэл хийхэд зориулан 10.0 сая, Б.Гэрэлсүрэн царгас тариалахад зориулан 7.0 сая, Сагил сумын*

иргэн Д.Мөнхбаяр тоосго үйлдвэрлэлд зориулан 18.9 сая төгрөгийн зээл авсан үйл ажиллагаа явуулаагүй/

- Зээлийг зориулалт бусаар ашигласан /МУ-ын ЗГ-ын 2011 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 1.9³², 4.2.1³³, 4.2.3³⁴ заалтуудыг зөрчиж нийт 6,704.6 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан нь нийт зөрчлийн хамгийн өндөр буюу 49.4 хувийг эзэлж байна/;
- Зээлдэгчдийн үйл ажиллагаа тогтворжоогүй; /Баянхонгор 83,400.0, Сүхбаатар 337,712.5, Ховд 184,970.6, Говь-Алтай 164,108.0, Төв 133,000.0, Өмнөговь 118,499.7, Хэнтий аймагт 374,500.0 сая төгрөг, нийт 1,393.2 сая төгрөгийн зээл аваад үйл ажиллагаа явуулаагүй/
- Зээлийн эргэн төлөлтийг гэрээний дагуу төлөөгүй, хугацаа хэтрүүлсэн /журмын 3.2.3³⁵, 4.7³⁶ дахь заалтыг зөрчсөн / 3,397.5 сая төгрөгийн зээлийн төлбөрийг хугацаанд нь эргэж төлөөгүй байна/;
- Зээлийн эргэн төлөлтийн хуваарийг зөвхөн хүү төлүүлэх хэлбэрээр хийж, зээлийн хөрөнгийн эргэлтийг удаашруулсан;
- Хугацаа хэтэрсэн зээл болон зээлийн хүүгийн үлдэгдэлд гэрээний дагуу торгууль ногдуулаагүй;
- Нэг гэр бүлийн хүмүүст /эхнэр,нөхөрт/ зээл олгосон; /Дархан сумын иргэн Д.Оюун 2012 онд авсан 7.3 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байхад 2013 онд нөхөр Т.Батчулуунд Гурван гансага ХХК-ний нэрээр 10.0 сая төгрөгийн зээл олгосон, Говьсүмбэр аймагт ийм зөрчил байгаа/
- Зээл олгохдоо барьцаа хөрөнгийг хангалттай аваагүй, барьцааны гэрээг хангалтгүй буюу огт хийгээгүй, зээлийн батлан даагч /хамтран эзэмшигч/ байхгүй /Сэлэнгэ аймгийн Мандал суманд 14 иргэнд барьцаагүйгээр 263.1 сая төгрөгийн зээл олгосон/;
- Зээл олгох үйл ажиллагааг журмын дагуу явуулдаггүй /Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн суманд 2013 онд 72 зээлдэгчид Засаг даргын захирамжгүй 152.2 сая, Мандал сумын иргэн Д.Цэрэнхоролд 165.0 сая төгрөгийн зээл олгож сумын ИТХ-аар тогтоосон зээлийн батлагдсан хэмжээнээс 115.0 сая төгрөг илүү олгож журмын 4.1.4³⁷-г зөрчсөн/;
- Сумдын хяналтын зөвлөл огт ажиллаагүй, хяналтын зөвлөл байгуулаагүй, зээлийн эргэн төлөлтөд хяналт тавиагүй, ажлаа сумын ИТХ-д тайлагнаагүй, /Төв аймгийн Баянчандмань сум хөгжүүлэх сангийн төсөл шалгаруулах зөвлөл байгуулагдаагүй, Дархан-Уул аймаг хяналтын зөвлөл байгуулсан боловч хяналт тавиагүй, хяналтын тайлан байхгүй/;
- Төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүдийн мэдлэг чадвар дутмаг, өөрсдийн үзэл бодол, танил талыг харж зээл олгосон; /Говь-Алтай аймагт төрийн албан хаагчид зээл олгосон/
- Төсөл шалгаруулах ажлын хэсэгт орон нутгийн ИТХ-ын төлөөлөгчдийг иргэний төлөөлөл хэмээн оруулах, зөвлөлийг иргэний төлөөлөл оруулахгүйгээр байгуулсан;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ажилтай давхардсан зориулалтаар зээл олгодог; /Архангай амьгийн Жаргалант сум Сум хөгжүүлэх сангаас иргэн Ч.Батсайханд 25.0 сая төгрөгийн зээлийг дэд станц барих чиглэлээр олгосон бөгөөд энэ нь сумын 2013 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ажилтай давхардсан/
- Сум хөгжүүлэх сангийн зээлийн төлөлт дуусаагүй байхад дахин олгож, давхар төлөлттэй явдаг; /Увс аймгийн Бөхмөрөн сум 11 зээлдэгчид 37.0 сая, Өлгий сум 3 зээлдэгчид 17.0 сая, Түргэн сум 2 зээлдэгчид 4.5 сая, нийт 16 зээлдэгчид 58.5 сая төгрөгийн зээлийг дахин олгосон байна/

³² Сангийн хөрөнгийг сумын төсвийн алдагдал нөхөх, төсөвт байгууллагын ажиллагааг санхүүжүүлэх, байгалийн гамшгаас учирсан хохирлыг нөхөн төлөх зэргээр энэхүү журмын 1,5-д зааснаас бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно.


³³ Иргэн аж ахуйн нэгж нь харьяаллын хувьд тухайн суманд бүртгэлтэй байх

³⁴ Зээлийн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглах, зээлээ хугацаанд нь төлөх төлбөрийн чадвартай байх

³⁵ Төсөл нь шалгарсан иргэн аж ахуйн нэгжтэй зээлийн гэрээ байгуулж хэрэгжилтийн явц, үр дүнд байнгын хяналт тавьж ажиллах

³⁶ Иргэн аж ахуйн нэгж олгосон зээлийн хөрөнгө, зээлийн хүүг гэрээнд заасан хугацаанд сум хөгжүүлэх сангийн дансанд эргэн төлнө

³⁷ Төслийг хэрэгжүүлэх явцад учирч болзошгүй эрсдлийг бодитой тодорхойлсон, эрсдлийг даван туулах талаар тусгасан байх



СХС-ийн зарцуулалтад хийсэн аудитаар 10,657.8 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 4,337.6 сая төгрөгийн 181 төлбөрийн акт тогтоож, 144 албан тушаалтанд 5,490.4 сая төгрөгийн хугацаатай албан шаардлага хүргүүлэв.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

Орон нутгийн хөгжлийн сангийн талаар:

1. ОНХС-ийн орлогыг төлөвлөх, гүйцэтгэлийг хэрэгжүүлэхдээ Төсвийн тухай хууль, Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам, ОНХНС болон ОНХС-аас олгох шилжүүлэг тооцох аргачлалыг орон нутаг бүрт жигд баримтлаж ажиллаагүй байна.
2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэхдээ иргэд, олон нийтийн оролцоо, ил тод байдлыг хангах талаар хууль, журамд тусгасан заалтуудыг бүрэн хэрэгжүүлээгүй, тэдгээрийн хэрэгжилтийг иргэд, олон нийтийн хяналтад оруулах ажлыг ихэнх аймгууд зохион байгуулаагүй байна.
3. МУ-ын Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолын ОНХС-ийн хөрөнгийг хуваарилахад ашиглах сум, дүүргийн хөгжлийн индексийг тооцох нийтлэг аргачлалыг боловсруулж батлуулахаар заасан заалт хэрэгжээгүй байна.
4. Орон нутгийн удирдлага, тухайн ажил хариуцсан албан тушаалтнуудын ОНХС-ийн хөрөнгөөр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах мэдлэг чадвар дутмаг, хариуцлага сул байна.

Сум хөгжүүлэх сангийн талаар:

5. Орон нутгийн удирдлага, холбогдох албан тушаалтнууд зээлийг журам зөрчиж олгосон, зориулалтын дагуу ашиглаагүй, эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн байхад шинээр зээл олгож байгаа зэрэг хууль тогтоомжид нийцэхгүй үйл ажиллагаа явуулсан нь СХС-ийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалтын үр дүнг бууруулж байна.
6. СХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төслийн сонгон шалгаруулалтад эдийн засгийн тооцоо, судалгаа, үндэслэл муутай, чанаргүй төсөл шалгарч байгаа нь орон нутагт амьдарч байгаа иргэдийн төсөл боловсруулах мэдлэг хомс, үүнд тусалж зөвлөх, мэргэжил арга зүйн дэмжлэг, үйлчилгээ байхгүй байгаатай холбоотой байна.
7. Төслийн сонгон шалгаруулалт хууль журмын дагуу явагдахгүй байгаа нь орон нутгийн Засаг дарга, ажил хариуцсан албан тушаалтнуудын холбогдох хууль тогтоомж, ялангуяа худалдан авах ажиллагааны талаарх мэдлэг сул байгаатай холбоотой байна.
8. СХС-ийн орон тооны бус зөвлөлийн хяналт, ИТХ, ЗД-ын үүргийн биелэлт хангалтгүй, ажлаа сумын ИТХ-д тайлагнадаггүй, зөрчил гаргасан хүмүүст хариуцлага хүлээлгэх ажиллагаа журмын дагуу явагдахгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Монгол Улсын Засгийн газарт:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн чиглэлээр

- МУ-ын Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолын 4 дэх заалтын дагуу ОНХС-ийн хөрөнгийг хуваарилахад ашиглах сум, дүүргийн хөгжлийн индексийг тооцох нийтлэг аргачлалыг батлуулж мөрдөх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалт, түүнд хяналт тавих эрхээ хэрэгжүүлээгүй, зөрчил гаргаж байгаа шат шатны албан тушаалтанд хуулийн дагуу ажлын хариуцлага тооцох;
- ОНХС-ийн хөрөнгөөр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах талаар орон нутгийн удирдлага, албан тушаалтнуудын мэдлэг, чадварыг сайжруулах;

2. Сум хөгжүүлэх сангийн чиглэлээр

- Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, зээлийн эргэн төлөх хугацаа хэтэрсэн, үйл ажиллагаа явуулаагүй зэрэг чанаргүй зээлийн асуудлыг яаралтай шийдвэрлэх, чанаргүй төсөл сонгон шалгаруулсан, тэдгээрт зохих хяналт тавиагүй албан тушаалтанд хариуцлага тооцох талаар үүрэг чиглэл өгч биелэлтийг хангуулах;
- Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны хэрэгжилтийн талаарх ажлын тайланг хэлэлцүүлж, цаашид баримтлах чиглэлийг тодорхойлж шийдвэр гаргах;


Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн чиглэлээр

- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэд, олон нийтийн оролцоо, ил тод байдлыг хангах талаар хууль, журамд тусгасан заалтуудыг тууштай хэрэгжүүлж, тэдгээрийн хэрэгжилтийг иргэд, олон нийтийн хяналтад оруулах ажлыг зохион байгуулах;
- Иргэдийн гаргаж, дэмжсэн саналыг орон нутгийн хөгжлийн бодлого, хөтөлбөртэй уялдуулан эрэмбэлж, орон нутгийн хөгжилд үр өгөөжтэй, иргэдийн амьдралд тэргүүлэх ач холбогдолтой хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөх, худалдан авах ажиллагааг зохион байгуулахад ажил хариуцсан мэргэжилтнүүдийг сургаж мэргэшүүлэх;
- Төсвийн тухай хуулийг иргэдэд сурталчлах, төсөв төлөвлөх, бүрдүүлэх, хуваарилах, тайлагнах, хянах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах чиглэлээр иргэдэд тасралтгүй боловсрол олгох ажлыг эрчимжүүлэх;
- Сангийн хөрөнгөөр бэлтгэсэн хөрөнгийн ашиглалт, арчлалт, хамгаалалтыг сайжруулах, хөрөнгийг зориулалтаар нь ашиглаж, тооцоолсон үр ашиг, үр дүн гарч байгаа эсэхийг хянаж, үр дүнг тооцож ажиллах;

2. Сум хөгжүүлэх сангийн чиглэлээр

- Засгийн газрын 2011 оны 134 дугаар тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ыг чанд мөрдөж ажиллах;
- Сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтад хяналт тавих чиг үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагааг идэвхижүүлэн чанаргүй зээлийн асуудлыг яаралтай шийдвэрлэж, үр дүнг тооцож ажиллах.



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД
 15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
 С.Данзангийн гудамж, Засгийн газрын II байр,
 Утас/факс: (976-51) 26-74-68, http://www.mof.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
 АУДИТОР А.ЗАНГАД ТАНАА

2014-07-09 № 4-У/4036
 танай _____ -ны № 1928 -Т

Хүсэлт хүргүүлэх тухай

Танайхаас Орон нутгийн хөгжлийн сан(ОНХС) болон Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт"-д хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Сангийн яамнаас Төсвийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж эхэлсэн 2013 оны хувьд орон нутаг төсвөө хууль журамд хэрхэн нийцүүлж баталсан талаар хянан үзэж холбогдох зөвлөмжийг Сангийн сайдаас 2013 оны 2 дугаар сарын 8-ний 4-1/714 тоотгоор аймаг, нийслэлийн Засаг дарга нарт хүргүүлсэн. Иймд цаг хугацааны хувьд 2014 оны ОНХС-гийн төсвөө хэрхэн боловсруулж батлуулсан талаар аудит хийсэн бол илүү үр дүнтэй байхаар байлаа.

Аудитын дүгнэлтэд 2013 онд ОНХС-гийн эх үүсвэр бүрдээгүйгээс шалтгаалан орон нутагт 18.7 тэрбум төгрөг дутуу олгосноос шалтгаалан ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжих 349 төсөл, арга хэмжээ санхүүжилтийн эх үүсвэргүйгээс огт хэрэгжихгүй болсон, 272 төсөл арга хэмжээ эхлүүлсэн боловч бүрэн дуусаагүй байна гэжээ. "Заавар батлах тухай" Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалын дагуу ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр тухайн онд тооловж, ажлын гүйцэтгэл баталгаажсан боловч санхүүжилт хийгдээгүй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг дараа жилийн төсөвт тусгаж батлуулахаар туссан тул дээрхи төсөл арга хэмжээнүүд 2014 онд үргэжлэн хэрэгжих боломжтой юм.


ОНХС-гийн чиглэлээр Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт өгөх Зөвлөмжтэй санал нэг байгаа бөгөөд харин зөвлөмжийн биелэлтийг хангуулах, түүнд хяналт тавих талаар цаашид анхаарах нь зүйтэй гэж үзэж байна. Тайланд дурдсанаар нийтдээ 46180.8 сая төгрөгийн зөрчил илэрсэнээс, 30 орчим хувь нь зориулалт бусаар зарцуулсан зөрчил эзэлж буй гэсэн тул гарсан зөрчлийг аймаг тус бүрээр ялгэн ангилж манай ажлын хэрэгцээнд ирүүлнэ үү.

Дашрамд дурдахад УАГ-аас 2013 онд ОНХС-ийн үйл ажиллагаанд хийсэн аудитын тайланд ОНХС-ийн санал асуулгыг нийт өрхийн хэдэн хувь нь хамрагдсан тохиолдолд хүчинтэй гэж үзэх, санал асуулгыг хэн хэрхэн зохион байгуулах, хяналтыг хэрхэн зохион байгуулах зэрэг асуудлыг журамд тусгаагүй байна гэж дурдсаны дагуу эдгээр асуудлыг "Заавар батлах тухай" Сангийн сайдын 43 дугаар тушаалд тусган журамлалаа.

Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалтад хийсэн аудитын тайланд тусгайлан өгөх саналгүй байна.

Хүндэтгэсэн,

САЙД



Ч.УЛААН

ОНХНСангаас шилжүүлсэн эх үүсвэрийн хуваарилалт /сая.төг/

хэвсрэлт 1

№	Аймгийн нэр	Жилийн төлөвлөгөө				Нийт шилжүүлсэн				Зөрүү				Хувь
		Дотоодын НӨАТ	АМНАТ	Аймаг нийслэлээс товлоруулсан орлого дахин хуваарилах	Нийт	Дотоодын НӨАТ	АМНАТ	Аймаг нийслэлээс товлоруулсан орлого дахин хуваарилах	Нийт	Дотоодын НӨАТ	АМНАТ	Аймаг нийслэлээс товлоруулсан орлого дахин хуваарилах	Нийт	
1	Архангай	6,937.7	727.0	1,030.4	8,704.1	6,300.3	727.0	1,030.4	8,165.7	538.4	-	-	538.4	93.8
2	Баян-Өлгий	6,004.9	742.1	899.8	7,546.8	5,464.3	742.1	899.8	7,106.2	540.6	-	-	540.6	92.9
3	Баянхонгор	8,276.7	659.5	1,240.0	10,176.2	7,744.5	659.5	1,240.0	9,644.0	532.2	-	-	532.2	94.8
4	Булган	5,992.6	463.5	857.8	7,353.9	5,293.4	463.5	897.8	6,654.7	599.2	-	-	599.2	90.5
5	Говь-Алтай	8,258.9	463.6	1,237.3	9,959.8	7,380.2	463.6	1,237.3	9,081.1	878.7	-	-	878.7	91.2
6	Дорноговь	6,621.2	517.2	952.0	8,130.4	6,137.3	517.2	992.0	7,646.5	483.9	-	-	483.9	94.0
7	Дорнод	7,224.7	600.8	1,052.4	8,907.9	6,426.0	600.8	1,052.4	8,109.2	798.7	-	-	798.7	91.0
8	Дундговь	6,696.3	323.8	1,003.2	8,023.3	6,179.3	323.8	1,003.2	7,506.3	517.0	-	-	517.0	93.6
9	Завхан	6,669.1	550.2	959.1	8,218.4	6,340.0	550.2	999.1	7,889.3	329.1	-	-	329.1	96.0
10	Өвөрхангай	7,583.3	866.7	1,136.1	9,586.1	6,786.8	866.7	1,136.1	8,789.6	796.5	-	-	796.5	91.7
11	Өмнөговь	7,948.6	598.6	1,150.8	9,798.0	6,982.7	598.6	1,190.8	8,772.1	965.9	-	-	965.9	90.1
12	Сүхбаатар	6,915.2	445.7	1,036.0	8,396.9	6,908.7	445.7	1,036.0	8,390.4	6.5	-	-	6.5	99.9
13	Сэлэнгэ	5,496.7	854.0	823.5	7,174.2	5,038.8	854.0	823.5	6,716.3	457.9	-	-	457.9	93.6
14	Төв	5,991.2	732.9	897.6	7,521.7	5,336.1	732.9	897.6	6,966.6	555.1	-	-	555.1	91.4
15	Увс	6,495.0	627.2	973.0	8,095.2	5,953.7	627.2	973.0	7,553.9	541.3	-	-	541.3	93.3
16	Ховд	7,068.5	666.4	1,050.0	8,792.9	6,334.9	666.4	1,050.0	8,050.3	733.6	-	-	733.6	91.7
17	Хөвсгөл	7,272.6	996.9	1,069.6	9,358.1	6,534.0	996.9	1,069.6	8,619.5	738.6	-	-	738.6	92.1
18	Хэнтий	6,748.5	572.8	1,011.1	8,332.4	6,511.7	572.8	1,011.1	8,095.6	236.8	-	-	236.8	97.2
19	Дархан-Уул	5,320.2	796.3	757.1	6,915.6	4,994.4	796.3	797.1	6,589.8	325.8	-	-	325.8	96.3
20	Улаанбаатар	21,428.3	10,392.0	3,210.3	35,030.6	14,765.2	10,089.4	3,210.3	28,064.9	6,863.1	302.6	-	6,965.7	80.1
21	Орхон	5,833.1	804.1	873.9	7,511.1	5,383.8	804.1	873.9	7,061.8	449.3	-	-	449.3	94.0
22	Говьсүмбэр	5,063.4	118.4	768.6	5,940.4	4,568.1	118.4	758.6	5,445.1	495.3	-	-	495.3	91.7
Нийт дүн		161,846.7	23,515.7	24,247.6	209,514.0	143,463.2	23,217.1	24,247.6	190,927.9	18,383.5	302.6	-	18,686.1	91.1

Хавсралт 2

ОНХНСангаас шилжүүлсэн эх үүсвэрийн бүрдүүлэлт, хэрэгжсэн төсөл хөтөлбөр

№	Аймгийн нэр	ОНХНС аас олгосон санхүүжилт					Орон нутгийн орлого				Нийт орлогын дүн	Батлагдсан төсөл хөтөлбөр		Хэрэгжсэн төсөл хөтөлбөр	
		Алх батлагдсан дүн	шилжүүлсэн	Зөрүү	Ирсэл санхүүжилтийн хувь	Төсвийн үндсэн тэнцлийн ашгаас үлдэх хэсэг	Татварын хувь хэмжээг нэмэгдүүлсэн	Хандив	Бусад	Нийт		Тоо	Төсөвт өртөг сая/төг	Тоо	Төсөвт өртөг сая/төг
1	Архангай	8,704.1	8,165.6	538.5	93.8		35.0	40.0	75.0	8,240.6	325	3,779.1	225	7,069.4	
2	Баянхонгор	10,176.2	9,644.0	532.2	94.8			20.4	20.4	9,664.4	423	12,149.5	372	10,088.9	
3	Баян-Өлгий	7,646.6	7,106.1	540.5	92.9					7,106.1	324	7,998.1	316	7,964.1	
4	Булган	7,353.9	6,654.7	699.2	90.5					6,654.7	313	5,565.9	23	5,771.6	
5	Дархан-Уул	6,915.5	6,589.8	325.7	95.3			73.9	73.9	6,663.7	145	5,995.5	142	6,211.7	
6	Дорнод	8,907.9	8,109.2	798.7	91.0					8,109.2	252	3,292.1	227	6,645.0	
7	Дорноговь	8,130.4	7,646.5	483.9	94.0					7,646.5	180	3,130.2	157	7,133.1	
8	Говь-Алтай	8,023.4	7,506.4	517.0	93.6		10.5		10.5	7,516.9	257	3,060.5	123	5,417.0	
9	Говь-Алтай	9,959.8	9,081.1	878.7	91.2					9,081.1	495	9,959.8	428	6,246.7	
10	Говьсүмбэр	5,940.1	5,445.0	495.1	91.7			144.9	144.9	5,589.9	141	5,548.0	130	6,462.0	
11	Хэнтий	8,332.4	8,095.6	236.8	97.2		41.1	82.9	1,120.1	9,215.7	415	9,361.8	374	10,876.3	
12	Ховд	8,792.9	8,059.3	733.6	91.7		540.0		540.0	8,599.3	277	9,588.4	277	7,863.4	
13	Хөвсгөл	9,358.1	8,619.5	738.6	92.1		85.0		85.0	8,704.5	336	9,441.5	323	7,430.2	
14	Улаанбаатар	35,030.6	28,064.9	6,965.7	80.1			494.5	494.5	28,559.4	404	35,030.0	241	21,091.9	
15	Орхон	7,511.1	7,061.8	449.3	94.0		24.1		24.1	7,085.9	111	7,511.1	109	6,463.4	
16	Сэлэнгэ	7,174.2	6,716.3	457.9	93.6		9.9	10.9	107.8	6,824.1	241	7,174.2	216	6,242.5	
17	Сүхбаатар	8,396.9	8,390.4	6.5	99.9		775.2	1,081.7	1,856.9	10,247.3	229	10,989.8	225	10,560.1	
18	Төв	7,621.7	6,966.6	655.1	91.4		1,093.4	316.5	1,409.9	8,376.5	55	4,118.6	52	3,303.2	
19	Өмнөговь	9,739.0	8,772.1	966.9	90.1					8,772.1	247	11,409.6	210	5,036.0	
20	Увс	8,095.2	7,554.0	541.2	93.3					7,554.0	417	3,250.3	345	6,704.4	
21	Өвөрхангай	9,586.1	8,789.6	796.5	91.7					8,789.6	91	9,586.1	82	6,627.9	
22	Завхан	8,218.4	7,889.4	329.0	96.0	440.0			440.0	8,329.4	278	9,698.8	243	7,748.8	
Нийт дүн		209,613.5	190,927.9	18,686.6	92.7	440.0	946.2	1,184.0	6,403.0	197,330.9	5,956	215,638.9	4,840	170,957.6	

/сая.төг/



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2014 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 248

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах
тухай

“Төрийн аудитын тухай хууль”-ийн 13 дугаар зүйлийн 13.4.5, “Гүйцэтгэлийн шалгалтын журам”-ын 23.2, “Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам”-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. “Орон нутгийн хөгжлийн сан болон Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт”-д хийсэн аудитын тайланг баталсугай.

2. Аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хороо, Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яаманд хүргүүлсүгэй.

3. Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2014 оны 10 дугаар сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Сангийн сайд, Эдийн засгийн хөгжлийн сайд нарт зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын дарга (Б.Алтанзул), аймаг, нийслэлийн тэргүүлэх аудитор нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД